


# ТӨРИЙН БАЙГУУЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ 2016

## МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



Улаанбаатар

2016 он

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал: Мониторингийн тайлан” 2016 судалгааг IRIM Судалгааны хүрээлэн 5 дахь жилдээ хийж гүйцэтгэв.

Мониторингийн багийн зохицуулагч	Лхагваноровын Дашзэвэг, <i>IRIM судалгааны хүрээлэнгийн Судалгааны менежер, Социологич</i>
Зөвлөх:	Цэдэндамбын Батсугар, <i>IRIM судалгааны хүрээлэнгийн Үйл ажиллагаа хариуцсан захирал, Эрх зүйн магистр</i>
Судлаач:	Алтанхуягийн Билгүүн, <i>IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач,</i> Батболдын Мөнхтулга, <i>IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач</i>

**АГУУЛГА**

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС	4
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	6
ДҮРСИЙН ЖАГСААЛТ	7
УДИРТГАЛ	9
БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ	11
1.1    МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	11
1.2    МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЦАГ ХУГАЦАА	11
1.3    МОНИТОРИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	11
БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН	15
2.1    ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ	20
2.2    ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	29
2.3    ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	38
2.4    АЙМГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ	48
2.5    УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	59
2.6    ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	70
ХАВСРАЛТ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД	77
ХАВСРАЛТ 2. АРГА ЗҮЙН ТАЙЛБАР	78
ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ЦАХИМ ХУУДСУУД	80
ХАВСРАЛТ 4. ЦАХИМ ХУУДСУУДЫН ЭРЭМБЭЛЭЛТ	82

## БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС

### Монгол Улсын яам

БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СЯ	Сангийн яам
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
УУЯ	Уул уурхайн яам
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам

### Хэрэгжүүлэгч агентлаг

АМГ	Ашигт малтмалын газар
АЕГ	Архивын ерөнхий газар
ГТГ	Газрын тосны газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ИХШХЕГ	Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар
ХОГ	Хөрөнгө оруулалтын газар
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МЭҮГ	Мал эмнэлэг, үржлийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОӨГ	Оюуны өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХҮЕГ	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар

### Тохируулагч агентлаг

МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦЭГ	Цөмийн энергийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**Парламентийн харьяа байгууллагууд**

ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
УИХ	Монгол Улсын Их Хурал

**Улаанбаатар хотын засаг захиргаа**

НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
-------	--------------------------------------

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин	14
Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт(хувиар)	20
Хүснэгт 3. ТОП 5 үзүүлэлттэй яам (хувь)	21
Хүснэгт 4. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 5 яам (хувь)	26
Хүснэгт 5. ХАА-ны ил тод байдал ТОП 3 яам (хувь)	28
Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	29
Хүснэгт 7. ТОП 5 үзүүлэлттэй хэрэгжүүлэгч агентлагууд (хувь)	30
Хүснэгт 8. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээТОП 3 (хувь)	35
Хүснэгт 9. Худалдан авах ажиллагааны ил тод байдлын үнэлгээ ТОП 3 (хувь)	36
Хүснэгт 10. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	38
Хүснэгт 11. ТОП 5 үзүүлэлттэй тохируулагч агентлагууд (хувь)	40
Хүснэгт 12. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)	44
Хүснэгт 13. ХАА-ны ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)	46
Хүснэгт 14. Аймгуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	48
Хүснэгт 15. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь)	49
Хүснэгт 16. Хүний нөөцийн ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)	53
Хүснэгт 17. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 аймаг (хувь)	55
Хүснэгт 18. ХАА-ны ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)	57
Хүснэгт 19. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)	59
Хүснэгт 20. Нийслэлийн захиргаа. дүүргийн ТОП 5 байгууллага	60
Хүснэгт 21. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 дүүрэг (хувь)	64
Хүснэгт 22. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 нийслэл. дүүрэг(хувь)	66
Хүснэгт 23. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал ТОП 2 (хувь)	68
Хүснэгт 24. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)	70
Хүснэгт 25. Төсөв, санхүүгийн ил тод байдал ТОП 4 (хувь)	74
Хүснэгт 26. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд	78
Хүснэгт 27. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ	79
Хүснэгт 28. 2015 оны мониторингийн аргазүйд нэмж оруулсан шалгуур үзүүлэлтүүд	79

## ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан)	15
Дүрс 2. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал (хувиар харуулсан)	16
Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал (хувиар харуулсан)	16
Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал (хувиар харуулсан)	17
Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал (хувиар харуулсан)	18
Дүрс 6. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (хувиар харуулсан)	18
Дүрс 7. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан)	21
Дүрс 8. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)	22
Дүрс 9. Яамдын цахим хуудас дахь байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	23
Дүрс 10. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	25
Дүрс 11. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	26
Дүрс 12. Яамдын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт (хувь)	27
Дүрс 13. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)	28
Дүрс 14. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)	30
Дүрс 15. Хэрэгжүүлэгч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)	31
Дүрс 16. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	32
Дүрс 17. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	33
Дүрс 19. Хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	34
Дүрс 18. Хэрэгжүүлэгч агентлагын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	35
Дүрс 20. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)	36
Дүрс 21. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	37
Дүрс 22. Тохируулагч агентлагуудын ил тод байдал (хувь)	38
Дүрс 23. Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	39
Дүрс 24. Тохируулагч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)	40
Дүрс 25. Тохируулагч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	41
Дүрс 26. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	42
Дүрс 27. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	42
Дүрс 28. Тохируулагч агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	43
Дүрс 29. Тохируулагч агентлагуудын санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	44
Дүрс 30. Тохируулагч агентлагуудын ХАА-ны үзүүлэлт (хувь)	47
Дүрс 31. Аймгуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)	49
Дүрс 32. Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	50
Дүрс 33. Аймгуудын ерөнхий мэдээлэл (хувь)	51
Дүрс 34. Аймгуудын цахим хуудасны олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	52
Дүрс 35. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	53
Дүрс 36. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	54
Дүрс 37. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	55
Дүрс 38. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	56
Дүрс 39. Аймгуудын цахим хуудасны ХАА-ны ил тод байдал (хувь)	57
Дүрс 40. Аймгуудын ХАА-ны ил тод байдал (хувь)	58



Дүрс 41. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)	60
Дүрс 42. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)	61
Дүрс 43. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн олон нийттэй харилцахтай холбоотой мэдээлэл (хувь)	62
Дүрс 44. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)	63
Дүрс 45. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	63
Дүрс 46. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	64
Дүрс 47. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	65
Дүрс 48. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)	67
Дүрс 49. Нийслэлийн захиргаа. дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)	68
Дүрс 50. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)	70
Дүрс 51. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)	71
Дүрс 52. Парламентын харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	72
Дүрс 53. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)	73
Дүрс 54. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	73
Дүрс 55. ХАА-ны ил тод байдал (хувь)	75
Дүрс 56. Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	76



## УДИРТГАЛ

Сайн засаглалын тулгын 3 чулуу бол хариуцан тайлагнах байдал (accountability), ил тод байдал (transparency), нээлттэй байдал (openness) билээ. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангах хэрэгсэл нь өнөөгийн нийгэмд тухайн байгууллагын цахим хуудас болоод байна. Монгол улс 2004 оноос хойш Монгол Улсын Засгийн Газрын (МУЗГ) мэдээлэл, харилцаа холбоо, технологийн (МХХТ-ийн) салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012 он) стратеги, “Цахим Монгол” (МУЗГ-ын 2005 оны тогтоол №216) үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Цахим Засгийн мастер төлөвлөгөө”, “Цахим засаг<sup>1</sup>” үндэсний хөтөлбөр (МУЗГ-ын 2012 оны тогтоол №101) зэрэг олон бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг үе шаттай батлан хэрэгжүүлж байна.

Төрийн байгууллагын вебсайтаар дамжуулан төрийн удирдлагын ил тод, нээлттэй хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор төрийн үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд хүртээмжтэй болгох, мэдээлэл олж авах орон зай, цаг хугацааны хамаарлыг арилгах, иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх, мэдээллээр хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, төрийн байгууллагын вебсайтыг улам төгөлдөржүүлэх, төрийн үйлчилгээнд вебд суурилсан системийг өргөнөөр нэвтрүүлэх арга хэмжээг бүх шатанд авахаар төлөвлөж зарим заалтууд хэдийн ажил хэрэг болж эхэлсэн байна.

Төрийн байгууллагын вебсайт дахь мэдээллийн ил тод байдлыг хангах зорилготой “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг Засгийн газрын 143 дугаар тоот тогтоолоор (цаашид “Тогтоол” гэх) батлан, уг шалгуурыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон байдаг. Уг тогтоол 2011 онд бүхлээрээ “Мэдээллийн ил тод байдал ба, мэдээлэл авах эрхийн хууль (МИТББМАЭТХ)” (2011.06.16)-ийн 2-р бүлэг болон батлагдсан билээ. Уг хуульд төрийн байгууллагын ил тод байдлыг хангахдаа *байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү болон худалдан авах үйл ажиллагаатай* холбоотой тодорхой мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудаст байршуулсан байхаар заасан юм.

Ерөнхийлөгчийн санаачлагаар 2014 оны 7 сард “Шилэн дансны тухай хууль” батлагдсан юм. Энэ хуулиар төрийн байгууллагуудын төсөв санхүү болон худалдан авах ажиллагааны ил тод байдлыг тухайн байгууллагын вебсайт болон шилэн дансны тусгай сайтаар иргэд хянах боломжийг хуульчилсан билээ.

Ил тод, нээлттэй байдлыг төрийн бодлого, эрх зүйн орчинд бүрдүүлсэн ч париктикт тэдгээрийн хэрэгжилт ямар хэмжээнд байгааг үнэлэх зайлшгүй шаардлага гарсан юм. Тухайлбал,

- 2010-2011 онуудад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилттэйгээр Авилгатай тэмцэх газартай хамтран ИРИМ судалгааны хүрээлэн “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ”-г хийж гүйцэтгэсэн.

<sup>1</sup> “Цахим засаг” (Electronic Government, E-Gov) гэж төрийн үйл ажиллагааг иргэдэд ил тод мэдээлэн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хангах, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглах замаар цахим үйлчилгээг тулгуур болгон улс орны дотоод, гадаад харилцаа, засаглалын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах үйл явцыг

(Төрийн байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-г илтгэсэн ЗГ-ын 143 дугаар тоот тогтоолын хэрэгжилтийн үнэлгээ)

- 2014 оноос жил бүр “Авилгатай тэмцэх газар”-ын захиалгаар Хараат бус шинжээчдийн багууд “Төрийн байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээ”-г хийж гүйцэтгэж байна. (Авлигатай тэмцэх газрын 2014 оны А/122-р тушаалын хэрэгжилтийн үнэлгээ)
- 2014, 2015 онуудад ИРИМ судалгааны хүрээлэн өөрийн санаачилгаар “Төрийн байгууллагын цахим хуудсын ил тод байдлын үнэлгээ”-г хийж гүйцэтгэсэн. (Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ)
- 2014 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны Академийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол Улсын цахим засгийн хууль эрх зүйн орчны өнөөгийн байдлын судалгаа” гэх зэргийг дурдаж болно.

IRIM судалгааны хүрээлэнгийн хувьд 2016 оны 9 сараас 12 сарын хооронд 5 дахь удаагаа “Төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээ”-г амжилттай зохион байгуулаад байна. Энэ удаагийн мониторингийн судалгааг өмнөх оны судалгаанаас ялгагдах байдлыг дараах онцлогуудаар харууллаа.

- ✓ ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн дагуу 81 байгууллагыг үнэлгээнд хамруулсан.
- ✓ Сонгуулийн дараа шинээр байгуулагдсан болон нэр цахим хуудсанд өөрчлөлт орсон байгууллагуудыг бүрэн хамруулсан.
- ✓ 2011 оноос хойш хийгдсэн цахим хуудсын үнэлгээний үр дүнг нэгтгэн харьцуулалт, шинжилгээ хийсэн.

## БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

### 1.1 МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэ судалгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудаст мониторинг хийж “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагын вебсайтад холбогдох ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд доорх зорилтууд тавьсан:

- Өнгөрсөн удаагийн мониторингийн арга зүйг зарчмын хувьд баримтлах. Ингэх нь харьцуулагдахуйц байдлыг хадгална. Гэхдээ үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал тус бүрээр үнэлэх
- Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг баримтлан хэрэгжилтийг үнэлэх
- Мониторингийн үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэх;
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.

### 1.2 МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЦАГ ХУГАЦАА

Мониторингийн мэдээллийг 2016 оны 09 сарын 10-оос 11 дугаар сарын 10-ны хооронд цуглуулсан бөгөөд энэ хугацаанд 81 байгууллагаас 80 байгууллагын албан ёсны цахим хуудас ажиллаж байсан.

Тодруулбал судалгаанд:

- Монгол улсын яам -13;
- Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг -17;
- Монгол улсын тохируулагч агентлаг -10;
- Монгол улсын орон нутгийн захиргаа- 21;
- Нийслэл, дүүргийн захиргаа - 11
- Улсын Их Хурал болон түүний харъяа байгууллага -9 хамрагдсан.

Энэ оны мониторингид судалгаанд хамрагдсан байгууллагуудаас “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-ны цахим хуудас нэвтрэх боломжгүй, мэдээллийг үнэлэх боломжгүй байсан. Мониторингийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны туршид дээрх цахим хуудсанд өдөр бүр нэвтрэх оролдлого хийж байсан. Үүнтэй зэрэгцэн [www.zasag.mn](http://www.zasag.mn) хуудсанд хандан тухайн байгууллагын холбоосоор нэвтрэх, [www.google.mn](http://www.google.mn) хуудаст байгууллагын нэрийг бичин хайлт хийж нэвтрэх оролдлогыг хийж байсан.

### 1.3 МОНИТОРИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Уг мониторингийн арга зүйд ашиглагдсан үндсэн үзүүлэлтүүд нь тухайн төрийн байгууллага хэр ил тод байгааг хэмжихэд чиглэгдсэн. Хэдийгээр ил тод байдлыг хэмжих олон янзын үзүүлэлт байдаг ч (тухайлбал улс төрийн, эдийн засгийн, хэвлэл мэдээллийн, хүний

эрхийн, бизнесийн өнцгөөс гэх мэт) энэ удаад үндсэн хоёр чиглэлээр шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

1. Холбогдох хуулиадад туссан мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн дөрвөн хүрээ болох “Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал”, “Хүний нөөцийн бодлогын ил тод байдал”, “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал” гэсэн мэдээллийн хүрээг авч үзсэн.
2. Засгийн газрын болон төрийн байгууллагын цахим хуудаст тавигддаг олон улсын нийтлэг шаардлага, стандарт (MNS 6285:2011 гэх зэрэг) үзүүлэлтүүдэд тулгуурласан.

Үзүүлэлтүүдийг боловсруулахдаа ХЭМЖИГДЭХҮЙЦ, ХЭРЭГЖИХҮЙЦ, БОДИТОЙ байх зарчмыг баримталсан. Мэдээллийн агуулгын шинжилгээг хийх нийтлэг шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага ил тод байдлын тодорхойлолтод ашигласан үндсэн гурван үзүүлэлт, НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн Комиссын ашигласан нэг үзүүлэлтийг хослуулснаас гадна ил тод байдлыг гэхээсээ илүүтэй цахим хуудсуудын чанарыг үнэлэхэд өргөн ашигладаг стандарт үзүүлэлтийг нэмж нийт таван үзүүлэлт бүхий дизайн боловсруулсан.

**Үзүүлэлт 1.** Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance): Төрөөс иргэдэд үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртэх боломжтой байдал. Нарийвчилбал, тухайн цахим хуудас нь МИТББМАЭТХ, ШДТХ-д цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуух 40 төрлийн мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ.

**Үзүүлэлт 2.** Мэдээллийн найдвартай байдал (Reliability): Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг илэрхийлнэ (Alanezi, Kamil, & Basri, 2010). Мөн МИТББМАЭТХ, ШДТХ-иуд дахь дөрвөн хүрээний дагуух 40 төрлийн мэдээлэл хэр найдвартай байгааг хэмжинэ.

**Үзүүлэлт 3.** Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness): Цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг хэмжинэ (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цагаа олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг, уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авч ашиглах боломжтой эсэхийг хянах юм.

**Үзүүлэлт 4.** Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility): Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ дээрх гурван шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийх юм.

**Үзүүлэлт 5.** Хэрэглэхэд хялбар байдал Usability): Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэх. Үүнд цахим хуудсуудын туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэт хэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дээрх үндсэн таван үзүүлэлтийн тусламжтайгаар төрийн байгууллага цахим хуудсаараа дамжуулан МИТББМАЭТХ, ШДТХ-д заасан үндсэн дөрвөн хүрээний мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг хэмжих юм.


Онцлон тэмдэглэхэд, хэдийгээр МИТББМАЭТХ, ШДТХ-д заасан мэдээллийн зарим хүрээ, тухайлбал хүний нөөц, төсөв, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл тухайн төрийн байгууллагын албан ёсны цахим хуудаснаас тусдаа нэгдсэн цахим хуудаст байрладаг боловч цахим хуудас бүр дээр эдгээр мэдээллийг тавихад хориглох зүйлгүй гэж үзэн мониторингийн үнэлгээнд хамруулсан болно. Жишээлбэл, аль нэг төрийн байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн талаарх мэдээлэл шууд тавигдаагүй боловч энэ талаарх мэдээллийг авч болох холбоос (Төрийн албаны зөвлөлийн холбоос гэх мэт), мөн төсөв, санхүүгийн талаарх мэдээлэл тавигдаагүй байсан ч энэ талаарх мэдээллийг авч болох шилэн дансны нэгдэн сайттай холбогдох тусгай цэс, холбогдох албан тушаалтны хаяг зэрэг багтсан байвал дээрх хүрээний мэдээлэл агуулагдсан хэмээн үнэлэх боломжтой. Ингэснээр цахим хуудсуудыг шалгуурын нэгдсэн түвшинд хамруулж олон төрлийн цахим хуудсыг хооронд нь харьцуулах боломжтой болсон.

**Мэдээлэлд шинжилгээ хийсэн арга.** Хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж жагсаалт гаргах нь мониторингийн нэг зорилт юм. Ил тод байдлын хэрэгжилтийг үнэлэхдээ үндсэн гурван хэлбэрээр шинжилгээг гаргасан нь:

1. Тухайн үзүүлэлтийн хэрэгжилт цахим хуудсуудад ямар түвшинд байгааг хэмжүүр тус бүрээр хувь тооцож үнэлэх
2. Өмнөх судалгаатай харьцуулагдахуйц байдлаар үзүүлэлтүүдийг харуулах
3. Байгууллага тус бүрийн үзүүлэлтүүдээс авсан оноо, хувийг эрэмбэлж, хавсралтад харуулах

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ гэдгийг ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг Дүрс 1-д харуулав.

Дүрс 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь



Мэдээллийн холбогдолтой байдал мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүдээс хамгийн өндөр буюу 30%-ийг эзэлж байгаа. Энэ нь цахим хуудаст тогтоолд заасан мэдээллийн бүх хүрээ ямар нэг байдлаар тавигдсан байгааг илтгэнэ. Тиймээс энэ нь ил тод байдлыг үнэлэх хамгийн чухал үзүүлэлт болох юм.

Харин тухайн мэдээлэл нь чанарын хувьд ямар мэдээлэл байна вэ гэдэгтэй холбоотой хоёр үзүүлэлт байгаа бөгөөд нийт үнэлгээний системд тус бүр 20 хувь, нийлээд 40 хувь эзэлнэ (мэдээллийн найдвартай ба цаг үеийн байдлын үзүүлэлтүүд).

Эцэст нь мэдээлэл хэрхэн хүрч байна вэ гэдэгт цахим хуудасны хүртээмжтэй байдал, хэрэглэхэд хялбар байдал багтсан бөгөөд эдгээр нь илүү хэлбэрийн шинжтэй үзүүлэлт тул нийт үнэлгээний системд тус бүр 15 хувь (мэдээллийн хүртээмжтэй байдал ба хэрэглэхэд хялбар байдал), нийт 30 хувийг эзэлж байна.

Мөн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэхдээ өмнөх мониторингийн арга зүйд ашигласан “шалгуурыг хангасан”, “шалгуурыг хангаагүй” гэсэн үнэлгээг нарийвчилсан. Тухайлбал, тухайн үзүүлэлтийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудсуудын үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон утгаар хэмжих оролдлого хийсэн. Хэмжилтээр гарч ирсэн үр дүнг тухайн үзүүлэлт тус бүрээр уг мониторингийн ажилд хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаа вэ гэдгийг дараах хүснэгтээс харж болно.

**Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин**

Хувь	Холбогдолтой байдал	Найдвартай байдал	Цаг үеийн байдал	Хүртээмжтэй байдал	Хэргэлэхэд хялбар байдал	Ил тод байдал
81-100	Бүрэн холбогдолтой	Мэдээлэл бүрэн найдвартай	Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг	Бүрэн хүртээмжтэй	Хэрэглэхэд маш хялбар	Бүрэн ил тод
61-80	Холбогдолтой	Найдвартай	Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг	Хүртээмжтэй	Хэрэглэхэд боломжтой	Ил тод
41-60	Зарим талаар холбогдолтой	Зарим талаар найдвартай	Зарим мэдээлэл шинэчлэгддэг	Зарим талаар хүртээмжтэй	Хэрэглэхэд төвөгтэй	Зарим талаар ил тод
0-40	Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй	Найдваргүй	Хоцрогдсон мэдээлэл	Хүртээмжгүй	Хэрэглэхэд маш төвөгтэй	Хаалттай


Дээрх таван үзүүлэлт тус бүрийн үнэлгээний түвшний дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 2 хэсгээс харна уу.



## БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан нийт төрийн байгууллагуудын цахим хуудсуудын дундаж үзүүлэлтийг 4-н оноор харьцуулан танилцуулна. Мөн гол шалгуур үзүүлэлтүүд болох “хамааралтай байдал”, “найдвартай байдал”, “цаг үеийн байдал”, “хүртээмжтэй байдал”, “хэрэглэхэд хялбар байдал” гэсэн үзүүлэлтүүдээр харуулна.

Дүрс 1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан)



Төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээний сүүлийн жилүүдийн үр дүнг 2011 онтой харьцуулахад бүгд сайжирсан, эерэг үзүүлэлтийг харуулж байна. Ялангуяа 2015 оны үнэлгээний үр дүн 2014 оноос 15 орчим хувиар, 2016 оноос 6 орчим хувиар сайн үнэлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлтийг харуулж байна. Сүүлийн 2 жилийн үнэлгээний хувьд 40-өөс дээш хувьтайгаар үнэлэгдсэн нь төрийн байгууллагын цахим хуудсын ил тод байдал “хаалттай” гэсэн ангилалаас “зарим талаар ил тод” гэсэн ангилалд шилжсэн хэрэг юм.

Энэ нь нэг талаас төрийн байгууллагууд цахим хуудсын ил тод байдлаа сайжруулах талаар анхаарч байгаатай холбоотой бол нөгөө талаас “Шилэн дансны тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдон мэдээллийн ил тод байдал сайжирсан гэж үзэж болно. Үнэлгээний сүүлийн 2 жилийн үр дүнгээс харахад төрийн байгууллагуудын 60 орчим хувь нь цахим хуудсандаа шинэчлэлт хийж өнгө дизайн болон мэдээллийн ил тод байдалдаа анхаарсан байна. Мөн шилэн дансны хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төрийн байгууллагуудын 90 орчим хувь нь тусгайлсан цэс бий болгож, холбогдолтой мэдээллийг ил тод болгож байна.


Төрийн байгууллагууд жил бүрийн үнэлгээнд жигд бус өөрлөлтийг үзүүлж байгааг дээрх дүрсээс харж болох юм. Тухайлбал 2011 онд яамд, 2014 онд аймгууд, 2015 онд яамд, 2016 онд нийслэл дүүргийн цахим хуудсын үнэлгээ бусдаас өндөр хувьтай үнэлэгдсэн байгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудсын ил тод байдал тогтворжоогүй байгааг илтгэж байна.



### Мэдээллийн хамааралтай байдал

Энэ хэсэгт ЗГ-ын 143 дугаар тогтоолд цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуу 40 төрлийн мэдээллийг цахим хуудсандаа ил тод болгож буй эсэхийг үнэлсэн.

Дүрс 2. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал (хувиар харуулсан)




Төрийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаанд хамааралтай мэдээлэл (үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа)-ийг цахим хуудсандаа нийтэлдэг байдал ерөнхий үзүүлэлттэй харьцуулахад жигд дээгүүр байна. Мэдээллийн хамааралтай байдлын үзүүлэлт нь 2015 оны үнэлгээгээр ихэнх төрийн байгууллагад хамгийн сайн үзүүлэлтийг харуулжээ. Сүүлийн 2 жилийн судалгааны үр дүнгээс харахад нийслэл, дүүргийн мэдээллийн хамааралтай байдлын үзүүлэлт бусад төрийн байгууллагаас илүү байгааг дээрх дүрсээс харж болох юм. Эсрэгээр парламентийн байгууллагууд болон агентлагуудын мэдээллийн хамааралтай байдлын үнэлгээ бусад төрийн байгууллагаас муу үр дүнг харуулж байна.

### Мэдээллийн найдвартай байдал

Мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтийг тухайн цахим хуудаст тавьсан мэдээллийн эх сурвалж, нийтэлсэн хүний овог нэр байгаа эсэх зэрэг үзүүлэлтийг авч үзсэн юм.

Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал (хувиар харуулсан)




Мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтүүд 2011 болон 2014 оны судалгааны үр дүнгээр маш хангалтгүй үнэлэгдсэн байна. Сүүлийн 2 жилийн үнэлгээнд төрийн байгууллагын цахим хуудсын найдвартай байдал нэлээд хувиар өссөн байна. Тэр дундаа 2016 оны үнэлгээнд парламентын байгууллагуудын мэдээллийн найдвартай байдал огцом өссөнг дээрх дүрсээс харж болно. Өмнөх оны судалгааны үр дүнгээр бусдаасаа өндөр үнэлгээтэй байсан тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны найдвартай байдлын хувь энэ оны судалгааны үр дүнгээр хамгийн бага хувьтай өсөлт үзүүлсэн байна. Харин нийслэл, дүүргүүд болон яамдуудын цахим хуудасны найдвартай байдлын үзүүлэлт 2015 онд 50 орчим хувиар огцом нэмэгдээд тогтворжсон байна.

### Мэдээллийн цаг үеийн байдал

Мэдээллийн цаг үеийн байдал гэдэгт төрийн байгууллагууд цахим хуудаа цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл оруулж чадаж байгаа эсэхээр үнэлсэн. (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цаг үеэ олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авч, ашиглах боломжтой байдлыг бүрдүүлж байгаа эсэхийг энэ үзүүлэлтээр хянах юм.

Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал (хувиар харуулсан)




Мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт төрийн байгууллагуудын хувьд өсөлттэй үр дүнг харуулж байна. Харин 2016 оны үнэлгээний үр дүнгээр тохируулагч агентлаг болон парламентын харьяа байгууллагуудын мэдээллийн цаг үеийн байдал буурсан байна. Нийслэл, дүүргүүдийн цахим хуудсын мэдээллийн цаг үеийн байдал 60 орчим хувьтай байгаа нь хамгийн сайн үзүүлэлт болж байна. Дээрх төрийн байгууллагуудаас парламентийн байгууллагуудын үнэлгээ “зарим талаар ил тод” гэсэн ангилалаас буурч “хаалттай” гэсэн ангилалд орсон байна.

### Мэдээллийн хүртээмжтэй байдал

Энэ үзүүлэлтээр цахим хуудас хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ өмнөх гурван үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус, цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийдэг.

Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал (хувиар харуулсан)




Мэдээллийн хүртээмжтэй байдлын хувь 43,5 хувь болсон нь өмнөх оны үр дүнтэй харьцуулж үзэхэд бага зэргийн өсөлттэй байдлыг харуулж байна. Дээрх дүрсээс харахад ихэнхи төрийн байгууллагуудын цахим хуудасны хүртээмжтэй байдлын үзүүлэлтэд эерэг өөрчлөлт гарчээ. Харин засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын үзүүлэлт 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 1 орчим хувиар буурсан сөрөг үзүүлэлттэй байна. Өмнөх жилийн судалгааны үр дүнгээр 33,8 хувьтай буюу тааруу дүгнэгдэж байсан яамдын цахим хуудасны хүртээмжтэй байдлын үзүүлэлт энэ оны судалгаагаар хамгийн өндөр ахиц гаргаж 53,3 хувь болсон нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

### Цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал

Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэхийг мөн хэмжсэн. Үүнд цахим хуудасны туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэт хэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дүрс 6. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (хувиар харуулсан)



Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй гардаг. Цахим хуудсын хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт 2015 оны үнэлгээний дүнгээр хамгийн өндөр буюу 76 орчим хувьтай үнэлэгдсэн байна. Харин 2016 онд төрийн байгууллагуудын цахим хуудсын хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт огцом буурч 55 орчим хувьтай үнэлэгдсэн нь сөрөг үзүүлэлт болж байна. Дээрх дүрсээс харахад өнгөрсөн онд хамгийн өндөр үзүүлэлт харуулж байсан парламентын байгууллагуудын үзүүлэлт 35 орчим хувиар буурч 60 хувьтай болсон байна.

## 2.1 ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 15 яамны албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Яамдын цахим хуудсыг таван үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

### Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт(хувиар)

№	Яам	Нийлбэр оноо				Эрэмбэ /Ранк/			
		2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	40.6	32.1	45.3	54.7	9	50	69	28
2	Монгол улсын гадаад харилцааны яам	27	27,8	56	48.5	47	60	29	37
3	Сангийн яам	47.2	39.2	74	62.6	3	31	1	10
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	-	25.8	<b>53.9</b>	<b>21.2</b>	-	63	<b>37</b>	<b>76</b>
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	63.1	35.9	59.5	33.7	1	39	19	65
6	Барилга, хот байгуулалтын яам	-	38.5	59.7	49.8	-	34	18	40
7	Монгол улсын батлан хамгаалах яам	33.4	33.1	46.2	51.8	24	45	63	37
8	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам	46	43.3	65.9	61.7	4	22	8	13
9	Зам, тээвэр хөгжлийн яам	-	46.1	67.4	56.9	-	16	3	19
10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	31.6	37.1	64.9	53.3	31	37	11	34
11	Эрчим хүчний яам	-	45.5	67.4	35	-	17	4	63
12	Эрүүл мэндийн яам	25.1	24.4	63.3	55.9	53	65	13	24
13	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	-	40.7	45.2	-	-	28	70	80
<b>Яамдын дундаж</b>		<b>39.2</b>	<b>36.7</b>	<b>58.5</b>	<b>45.2</b>				
<b>Ерөнхий дундаж</b>		<b>28.7</b>	<b>36.9</b>	<b>52.2</b>	<b>45.9</b>				

Яамдын цахим хуудсын үнэлгээний 2016 оны дундаж үзүүлэлт нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо үнэлгээтэй байна. Харин өмнөх жилүүдийн үнэлгээний үр дүнтэй харьцуулахад 2011 болон 2014 оноос өндөр, 2015 оны үзүүлэлтээс буурсан үр дүнг харуулж байна.


Яамдуудаас үнэлгээний дүнгээр Сангийн яам хамгийн өндөр (62.6 хувь) байгаа нь нийт төрийн байгууллагууд дунд 10-т эрэмбэлэгдэх үзүүлэлт болж байна. Харин хамгийн тааруу үзүүлэлт (21.2)-ийг Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас үзүүлсэн нийт төрийн байгууллагууд дунд 76-д эрэмбэлэгдэх үзүүлэлт болж байна. Үнэлгээний үр дүнгээр зарим яамдуудын үзүүлэлт өмнөх жилүүдтэй харьцуулахад нэлээд савалгаатай байгаа нь УИХ-ын сонгуулийн дараагаар ихэнх яамдын цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой.

Нийт 13 яамдаас Сангийн яам болон Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамдуудын цахим хуудас “ил тод” гэсэн ангилалд байгаа бол Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрчим хүчний яамдуудын цахим хуудас “хаалттай” гэсэн ангилалд хамаарч байна.

Энэ оны үнэлгээний дүнгээр яамдуудын үзүүлэлт болон ранк 2015 онтой харьцуулахад буурсан байгаа нь цахим хуудсын ил тод байдлыг хангах чиглэлээр хангалтгүй ажилласан болохыг илтгэж байна.

Яамдуудын цахим хуудасны мониторингийн үр дүнг таван үзүүлэлт тус бүрээр, 4 оноор харьцуулсан үр дүнг дараах графикт харууллаа.

Дүрс 7. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувиар харуулсан)



Дээрх дүрсээс харахад яамдын цахим хуудсын хэрэглэхэд хялбар байдал болон хамааралтай байдлын үзүүлэлт жил бүр бусад үзүүлэлтээс сайн үр дүнг харуулж иржээ. Харин мэдээллийн хүртээмжтэй, цагийн үеийн, найдвартай байдлын үзүүлэлтүүд харьцангуй бага хувьтай үнэлэгддэг байна. Энэ оны үр дүнгээр мэдээллийн цаг үеийн байдлаас бусад үзүүлэлт 2015 оны үнэлгээний үр дүнгээс буурсан байна. Гэсэн ч бүх үзүүлэлт нь 40 дээш хувьтай үнэлэгдэж, “зарим талаар ил тод” гэсэн ангилалд хамаарсан анхны тохиолдол болж байна.

Хүртээмжтэй байдлыг үнэлсэн шалгууруудаас “холбоотой байгууллагын холбоос линк” (100%), “хэлний сонголт” (93,3%) зэрэг нь маш өндөр үзүүлэлттэй байгаа бол “асуулт хариултын булан”, “тогтмол асуудаг асуултуудын хариулт”, “хэллэлцүүлгийн булан” зэрэг нь яамдуудын сайтанд муу үзүүлэлттэй байна.

Харин өнгө, үсгийн фонд, хэвлэх, илгээх, файл хадгалах зэрэг үзүүлэлтүүдийг багтаасан хялбар байдлын үзүүлэлт нь 79,7 хувиас 86,7 хувь болж дээшилжээ. Ашиглахад хялбар байдлын шалгуур үзүүлэлтүүд ихэнхи нь сайн үр дүнтэй гарсан байна.

Яамдуудын сайтыг ил тод байдлын үзүүлэлтээр жагсааж дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 3. ТОП 5 үзүүлэлттэй яам (хувь)

№	Яамдын нэрс	Нийлбэр оноо			
		2011	2014	2015	2016
1	Сангийн яам	47.2	39.2	74	62.6
2	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам	46	43.3	65.9	61.7
3	Зам тээвэр хөгжлийн яам	-	46.1	67.4	57
4	Эрүүл мэндийн яам	25.1	24.4	63.3	55.9
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	40.6	32.1	45.3	54.7

Зураг 1. Сангийн яамны цахим хуудсан дахь мэдээллийн ил тод байдлын жишээ




Дээрх 5-н яамдын цахим хуудсаас Сангийн яам, Зам тээврийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яамууд нь 3 жил дараалан топ үзүүлэлттэй яаманд багтаж байна.

### 2.2.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

**Байгууллагын ерөнхий мэдээлэл.** Яамдын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан яамдын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс буусан байдалтай байна.

Дүрс 8. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)



Дээрх дүрсээс харахад яамдууд “эрхэм зорилго”, “үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт”-ыг цахим хуудсанаа байршуулдаг байдал нь нэмэгдэж “бүрэн ил тод” гэсэн үнэлгээнд орохуйц болсон байна. Харин “үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”-ийг цахим хуудсандаа байршуулдаг байдал сүүлийн 2 жилд 70 орчим хувьтай байгаа нь бусад шалгуур үзүүлэлтээс доогуур хувьтай дүгнэгдсэн байна.




**Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.**

Байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийг дараах дүрсэд үзүүлсэн 8 үзүүлэлтээр хэмжсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад яамдууд холбоо барих мэдээллүүд болох утасны дугаар, хаяг, факсын дугаар зэрэг мэдээллүүдээ цахим хуудастаа байршуулах байдал ихэнхи үзүүлэлтийн хувьд нэмэгдсэн байна. Эдгээрээс “олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр” цахим хуудсанд байршуулах байдал 2015 онд хамгийн их хувиар буюу 6,2 хувиас 40 хувь болтлоо, 2016 онд 40-77 хувь болтлоо огцом дээшилсэн байна.

Эсрэгээр 2014 оны үнэлгээнээс “байгууллагын хаяг” “байгууллагын холбоо барих утас”, факсын дугаар” зэрэг үзүүлэлт сүүлийн 2 жилийн үнэлгээгээр буурсан ч 80 дээш хувьтай хэвээр байна.

Дүрс 9. Яамдын цахим хуудас дахь байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)



Яамдуудын хувьд “иргэд хүлээн авч уулзах цагийн хувиар”, “тухайн цахим хуудсаас шууд оператор ажилтантай холбогдох байдал”, “шуудангийн хаяг” гэсэн мэдээллүүдийг цахим хуудсандаа байршуулаагүй байдал их байна.


Ерөнхийд нь дүгнэхэд яамдын үйл ажиллагааны ил тод байдал 2014 онд 53,3 хувьтай, 2015 онд 67,1 хувь болж өссөн, 2016 онд 53,8 хувь болж буурсан үзүүлэлттэй байна.

### 2.2.2 Хүний нөөцийн ил тод байдал

Хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлтийг 2011 болон 2014 онд “хүний нөөцийн ил тод байдал” гэсэн хэсгийг дүгнэхдээ “сул орон тооны зар”, “албан хаагчийн ёс зүйн дүрэм” гэсэн 2 үзүүлэлтээр хэмжиж байсан бол 2015 оноос хуульд тусгагдсанчлан “хүний нөөцийн стратеги, түүнийг хянаж үнэлэх журам”, хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл” гэсэн 2 үзүүлэлт нэмэн оруулсан.

Энэ жилийн үнэлгээний үр дүнгээр хүний нөөцийн ил тод байдал 35 орчим хувьтай дүгнэгдсэн нь 2015 онтой харьцуулахад 2 дахин буурсан сөрөг үр дүнг харуулж буй хэрэг юм.

Дүрс 11. Яамдын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)



Хүний нөөцтэй холбоотой мэдээлэл 2015 оны үнэлгээний үр дүнгээр маш өндөр хувьтай цахим хуудсанд оруулагдсан байсан бол 2016 оны судалгаагаар огцом буурсан байна. Тэр дундаа “хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл”-ийг цахим хуудсанд оруулсан яамд огт байхгүй, “хүний нөөцийн стратеги, түүнийг хэрэгжилтийг хянаж үнэлэх журам”-ыг цахим хуудсаар мэдээлсэн байдал маш бага байгаа нь үнэлгээний үр буурахад нөлөөллөө.

Өмнөх жилүүдийн судалгаанд мэдээллийн эх сурвалжтай байдал маш бага хувьтай цахим хуудсанд тавигдаж байсан ба тэдгээр мэдээллийн эх сурвалж тодорхойгүй байдал ажиглагдаж байсан бол 2016 оны судалгаагаар мэдээллийн цаг үеийн байдлын хувьд ач холбогдлоо алдах тохиолдол их байна.

Зураг 2. Сангийн яамны хүний нөөцийн мэдээлэл




Дээрх зурагт харагдаж байгаачлан сангийн яамны цахим хуудаст хүний нөөцийн талаарх мэдээлэл агуулсан тусгай цэс байгаа бөгөөл тухайн цэсэнд энэхүү судалгааны хүний нөөцийн ил тод байдлыг үнэлэх шалгуур тус бүрээр дэд сонголттой цэс гаргасан байсан тул сайн жишээгээр орууллаа.

### 2.2.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 11 үзүүлэлтийн 7 нь өмнөх судалгаанд ашиглагдсан ба энэ жил шинээр 4 үзүүлэлт нэмж оруулсан юм. Эдгээр үзүүлэлтүүдээс “шилэн дансны тусгай цэс” нь байршуулсан байдал хамгийн өндөр хувьтай байгаа нь эерэг үр дүнг харуулж байна. Мөн өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулан харвал ихэнхи нь нэлээд хувиар өсөлттэй байгааг дараах дүрсээс харж болохоор байна.

Дүрс 10. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Энэ оны үнэлгээний үр дүнгээр ихэнх үзүүлэлтийн ил тод байдлын хувь буурсан байгаа ба тэр дундаа “санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт”, “аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл” зэрэг нь огт ил тод бус байна.

Яамдын цахим хуудсанд “шилэн дансны цэс байх”, байгууллагын тухайн жилийн төсөв, хагас бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, өмнөх оны төсөв зэргийн мэдээлэл хамгийн өндөр хувьтай ил тод болсон хэвээр байна.

Харин ил тод байдлын шалгуур тус бүрээр төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг авч үзвэл мэдээллийг ил тод болгож буй хамааралтай байдал болон мэдээллийн эх сурвалжтай байдал өмнөх оноос бага зэрэг буурсан байна. Харин мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт өнгөрсөн жилүүдээс өсөлттэй байна.

Дүрс 11. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийн ил тод байдал нь “шилэн дансны хууль”-аар зохицуулагдаж байгаа бөгөөд хууль хэрэгжиж эхэлсэн сүллийн 2 жилийн хугацаанд эх сурвалжтай байдал огцом өссөн байгааг дээрх дүрсээс харж болох юм.

Хүснэгт 4. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 5 яам (хувь)

Яамд	Мэдээлэл байгаа эсэх	Эх сурвалж тодорхой эсэх	Цаг хугацаа нь байгаа эсэх	Нийт хувь
Зам, тээвэр хөгжлийн яам	35	20.8	21.4	77.3
Сангийн яам	31.1	20.8	19.4	71.3
Барилга, хот байгуулалтын яам	31.1	20.8	19.4	71.3
Монгол улсын батлан хамгаалах яам	31.1	20.8	19.4	71.3
Боловсрол, соёл шинжлэх ухааны яам	31.1	20.8	19.4	71.3
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдэрийн яам	31.1	20.8	19.4	71.3


Дээрх хүснэгтээр “төсөв санхүүгийн ил тод байдал”-аар хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа 5-н яамыг жагсаасан болно. Зам, тээвэр хөгжлийн яам хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол бусад 4 яамд ижил 70 орчим хувьтай ард нь үнэлэгджээ. Гэсэн ч эдгээр топ үзүүлэлттэй яамд нь төсөв санхүүгийн мэдээллийн хувьд “бүрэн ил тод” гэсэн ангилалд хараахан багтаагүй байна.

Яамдаас төсөв санхүүгийн мэдээлэл агуулсан шилэн дансны тусгай цэсгүй болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэгдээгүй байгууллага байхгүй байна. Гэвч тухайн шилэн дансны цэс нь “шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд” холбогдох, түүндээ мэдээллээ оруулаагүй байх тохиолдол их гарч байна.

## 2.2.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Яамдын хувьд ХАА-ны тухай мэдээлэл буюу тендертэй холбоотой баримт бичгийг цахим хуудастаа цаг тухай бүрт нь байршуулах ёстой юм. Шилэн дансны хууль батлагдсантай холбогдуулан өмнө нь 4 үзүүлэлтээр хэмжигддэг байсан худалдан авах ажиллагааны ил тод байдал 2015 оноос 9 үзүүлэлтээр хэмжиж байна.


Дүрс 12. Яамдын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт (хувь)



Энэ жилийн хувьд худалдан авах ажиллагаатай холбогдолтой мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт мөн л буурсан үр дүнтэй байна. Тендер шалгаруулалтын явуулах журмыг ил тод болгосон байдал энэ онд “ил тод” гэсэн ангилалд ганцаараа хамаарахаар байна. Харин эсрэгээр “мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр” “тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй үндэслэл”, “ХАА-нд хийсэн аудитын дүгнэлт, шалгалтын дүн” зэрэг үзүүлэлт өнгөрсөн жилээс маш ихээр буурч, муу үр дүн харуулсан байна.

Мөн дээрх дүрсээс харахад өмнөх жилийн судалгааны үр дүнгээс төдийлэн дээшлээгүй ч гэсэн ХАА-нд хийсэн аудитын дүгнэлт, тайланг цахим хуудастаа байршуулах байдал нь нэмэгджээ. Харин эсрэгээрээ худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлангаа тавих байдал нь буурсан байна.

Дүрс 13. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)



Дээрх дүрсээс харахад 2014 оны хувьд яамдын ХАА-ны ил тод байдал 18,8 хувьтай байсан нь энэхүү судалгааны дүнгээр 43,6 хувь болж нэлээд хэмжээгээр өссөн байна. Гэвч ил тод байдал гэсэн шалгуурт ороход болоогүй байна. Нарийчилсан үзүүлэлтээс харахад ХАА-ны талаарх мэдээллийн найдвартай байдал буюу эх сурвалж тодорхой байдал зэрэг нь 10 орчим хувиар, цаг хугацааны тохиромжит байдал нь 3 орчим хувиар нэмэгдсэн байгааг харж болох юм.

Хүснэгт 5. ХАА-ны ил тод байдал ТОП 3 яам (хувь)

Яамд	Мэдээлэл байгаа эсэх	Эх сурвалж тодорхой эсэх	Цаг хугацаа нь байгаа эсэх	Нийт хувь
Сангийн яам	29.9	20	20.8	70.8
Батлан хамгаалах яам	25.7	17.2	18.2	61
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	25.7	14.3	16.9	56.8

Нийт судалгаанд хамрагдсан яамдаас хамгийн өндөр оноо авсан нь Эрчим хүчний яам (71,4%), Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Сангийн яам тус бүрдээ (65,6%) байна.

Нийт 16 яамны 50 хувь нь буюу найм нь ХАА-ны талаарх мэдээллийг ямар нэгэн байдлаар цахим хуудастаа ил тод байршуулсан байна.

## 2.2 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 17 хэрэгжүүлэгч агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

### Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Нэрс	Нийлбэр оноо				Эрэмбэ /Ранк/			
		2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
1	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар				44.2				50
2	Биеийн тамир, спортын газар				40				58
3	Цаг уур, орчны шинжилгээний газар	49	47.9	18.2	56.1	2	14	84	23
4	Гаалийн ерөнхий газар	32.4	43.4	54.9	42.9	27	21	35	55
5	Татварын ерөнхий газар	35.9	58.6	47	61.8	17	2	61	12
6	Улсын бүртгэл, оюуны өмчийн газар	33.9	49.4	56.6	60	23	10	26	18
7	Архивын ерөнхий газар	34.3	39	50.1	53	21	32	49	36
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	29.7	48.4	52.3	68.9	39	11	42	7
9	Гадаадын иргэн, харьяатын газар	36.2	45.1	41.2	65.8	15	19	74	9
10	Соёл урлагийн газар				53				36
11	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	24.4	17.4	40.3	70	57	73	75	5
12	Иргэний нисэхийн ерөнхий газар	31.5	32.8	31.7	71.9	32	47	82	3
13	Ашигт малтмал, газрын тосны газар	23.1	47.2	52	41.5	60	15	45	56
14	Мал эмнэлэг, үржлийн газар	31.8	30.4	48.8	46.9	29	57	52	46
15	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	38	30.9	45.3	70	12	54	67	11
16	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	43.9	37.3	43.4	11	5	36	73	78
17	Хүүхэд залуучуудын хөгжлийн газар	35.8	30	48.2	11	18	58	55	79
<b>Хэрэгжүүлэгч агентлагийн дундаж</b>			<b>36.4</b>	<b>44.5</b>	<b>50.6</b>				
<b>Ерөнхий дундаж</b>		<b>28.7</b>	<b>36.9</b>	<b>52.2</b>	<b>45.9</b>				


Хэрэгжүүлэгч агентлагуудын дундаж үзүүлэлт 2016 онд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 5 орчим дээгүүр байна. Мөн өмнөх жилүүдийн үнэлгээний дундаж үзүүлэлтээс 6 орчим хувиар өссөн байна. Нийт 17 агентлагаас 4 агентлагийнх нь ил тод байдлын оноо өмнөх судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр буурчээ. Харин 13 агентлагийн ил тод байдлын оноо өмнөх үр дүнгээс дунджаар 13.4 хувиар өссөн байна.

Нийт хэрэгжүүлэгч агентлагуудаас 3 агентлаг (Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар) нь цахим хуудасны үнэлгээгээр “ил тод” гэсэн ангилалд хамаарсанбол бусад байгууллагуудын хувьд “зарим талаар ил тод” гэсэн ангилалд багтаж байна. Хэрэгжүүлэгч агентлагаас хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа Иргэний нисэхийн ерөнхий газрын үнэлгээ нь (71.9 хувь) нийт төрийн байгууллагууд дунд 3-т эрэмбэлэгдэх үзүүлэлт болж байна. Харин эсрэгээр хамгийн муу үзүүлэлттэй байгаа Хүүхэд залуучуудын хөгжлийн газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үзүүлэлт нь нийт төрийн байгууллагууд дунд 78-79 байранд эрэмбэлэгдэж байна.



Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу 4 оноор харьцуулан, өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа.

**Дүрс 14. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)**



Хэрэгжүүлэгч агентлагын цахим хуудасны үнэлгээгээр мэдээллийн хамааралтай байдал болон цахим хуудсын ашиглахад хялбар байдлын үзүүлэлтүүд бусад шалгуур үзүүлэлтээс илүү өндөр хувьтай байна. 2016 оны судалгааны үр дүнгээр мэдээллийн хамааралтай, найдвартай, цаг үеийн байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хувь бусад жилүүдээс дээшилсэн бол мэдээллийн хүртээмжтэй байдал болон хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт буурчээ. Бусад төрийн байгууллагатай харьцуулахад хэрэгжүүлэгч агентлагын цахим хуудсын ил тод байдал ихэнх үзүүлэлтээр өссөн нь сайшаалтай үр дүнг харуулсан байна.

**Хүснэгт 7. ТОП 5 үзүүлэлттэй хэрэгжүүлэгч агентлагууд (хувь)**


Хэрэгжүүлэгч агентлагуудын нэрс	Нийлбэр оноо	
	2015	2016
Иргэний нисэх	31.7	71.9
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	40.3	70
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	52.3	68.9
Гадаад иргэн харьяатын газар	41.2	65.9
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	45.3	61.9

Өнгөрсөн онд эхний 5 байранд жагсаж байсан хэрэгжүүлэгч агентлагуудаас ШШГЕГ-ын цахим хуудас давтан шилдэг үзүүлэлттэй шалгарсан бол өмнөх жил өндөр үзүүлэлттэй байсан УБЕГ-ын цахим хуудас өөрчлөгдөж, ХАА-ны газрын цахим хуудас хаагдсан байна. Хэрэгжүүлэгч агентлагуудын хамгийн өндөр үзүүлэлттэй цахим хуудас “зарим талаар ил тод” гэсэн ангилалаас гарч байгаагүй бол 2016 онд топ 5-н үзүүлэлттэй агентлагуудын цахим хуудас бүгд “ил тод” гэсэн ангилалд хамаарч байна.

### 2.3.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал төдийлэн дээшлээгүй байна. Сүүлийн 2 жилийн үнэлгээнээс харахад хэрэгжүүлэгч агентлагууд байгууллагын “эрхэм зорилго”,-ыг цахим хуудсанаа байршуулдаг байдал нь “бүрэн ил тод” гэсэн үнэлгээнд орохуйц болсон байна.

Дүрс 15. Хэрэгжүүлэгч агентлагын ерөнхий мэдээлэл (хувь)



Хэрэгжүүлэгч агентлагын хувьд ерөнхий мэдээллүүдээс “тэргүүлэх чиглэл”-ийг цахим хуудсаараа ил тод болгох байдал сул байна. “Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”-ийг цахим хуудсандаа байршуулдаг байдал 30 орчим хувьтай байгаа нь өнгөрсөн оны үнэлгээнээс 10 гаруй хувиар буурчээ.

Дүрс 16. Хэрэгжүүлэгч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)



Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд байгууллагын холбоо барих мэдээллээс холбоо барих утас, байгууллагын хаяг, цахим шуудангийн хаяг, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, журам заавар зэргийг өндөр хувьтай ил тод болгосон байна.


Харин эсрэгээр тухайн цахим хуудаснаас шууд оператор ажилтантай шууд холбогдох боломж, шуудангийн хаяг, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хувиар зэргийг бага хувьтай ил тод болгосон байна.

2016 оны үнэлгээгээр 3-н төрлийн мэдээллийн ил тод байдал огцом сайжирсан байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм журам, хууль тогтоомж болон төрийн үйлчилгээ авахтай холбоотой мэдээллийн жагсаалт гэсэн үзүүлэлтүүд 40-60 орчим хувиар огцом өсөлт харуулжээ.

### 2.3.2 Хүний нөөцийн ил тод байдал


Хүний нөөцийн ил тод байдлыг 2014 онд зөвхөн сул орон тооны талаарх мэдээлэл байгаа эсэхээр хэмжиж байсан бол сүүлийн 2 жилийн хугацаанд “Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам”, “Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл”, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм” гэсэн үзүүлэлтүүдийг нэмж дараах дүрсэд үзүүлсэн 4 үзүүлэлтээр хэмжсэн.

Дүрс 17. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)



Энэ онд хэрэгжүүлэгч агентлагийн хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ энэ онд нэлээд хувьтай буурчээ. Албан хаагчийн ёс зүйн дүрэм нь 47 хувьтай үнэлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа ч өнгөрсөн оны үнэлгээтэй харьцуулахад их хувиар буурсан үзүүлэлт болж байна. Харин эсрэгээр хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг энэ онд огт ил тод болгоогүй байна.

Дүрс 18. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)




Хэрэгжүүлэгч агентлагийн хүний нөөцийн мэдээллийн шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээ 2016 онд өсчээ. Тэр дундаа цахим хуудсанд ил тод болсон хүний нөөцтэй холбогдолтой мэдээллийн эх сурвалжтай байдал болон цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдлын үзүүлэлтүүд 60 орчим хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Цаашид хүний нөөцийн мэдээллийн хамааралтай байдал буюу цахим хуудсад ил тод болгох байдлыг сайжруулах шаардлагатай байна.


### 2.3.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг 4-н жилээр харьцуулж дараах дүрсээр харууллаа.

Дүрс 19. Хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)



Хэрэгжүүлэгч агентлагуудын төсөв санхүүгийн холбогдолтой мэдээллийг үнэлэхэд “шилэн дансны тусгай цэс байршуулсан байдал” 60 дээш хувьтай байна. Бусад мэдээллүүдийн ихэнх нь 40-60 хувьтай үнэлэгдэж байна. Өнгөрсөн жилийн үзүүлэлттэй харьцуулахад төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлтүүд болон урьд оны төсвийн гүйцэтгэл гэсэн үзүүлэлтүүд нэлээд хувиар өссөн байна.

**Дүрс 20. Хэрэгжүүлэгч агентлагын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)**


Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийн хамааралтай байдал болон эх сурвалж тодорхой байдал бага хувиар өссөн байна. Харин цаг хугацааны хувьд тохиромжтой үед олон нийтэд нийтлэх байдал 2016 оны үнэлгээгээр буурсан үзүүлэлттэй байна.

Харин хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ, аудитын тайлан дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг цахим хуудсандаа ил тод болгох байдал бага хувьтай хэвээр байна.

**Хүснэгт 8. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээТОП 3 (хувь)**


Агентлаг	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодор-хой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Иргэний нисэхийн ерөний газар	15.6	38.9	10.4	26	9.2	21.5	35.2	86.4
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	19.5	35.02	13	23.4	11.2	22.5	43.7	80.9
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	27.2	35.02	18.2	23.4	18.4	19.4	63.8	77.8

Нийт 17 агентлагуудыг төсөв санхүүгийн мэдээллийг ил тод байдлаар жагсааж харахад Иргэний нисэхийн ерөнхий газар 86,4 хувиар 1 байранд байгаа нь өнгөрсөн жилийн топ үзүүлэлтээс 20 орчим хувиар илүү үзүүлэлт юм. ШШГЕГ-ын төсөв санхүүгийн мэдээлэл нь энэ онд 15 орчим хувиар өссөн ч өнгөрсөн жилийн амжилтаа хадгалж 3-р байрт багтсан байна. Харин ГЗБГЗЗГ нь өнгөрсөн оны үзүүлэлтээсээ даруй 2 дахин өндөр хувьтай үнэлэгдсэн нь сайшаалтай хэрэг болж байна.

### 2.3.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудаастаа ил тод байршуулах байдал өмнөх судалгааны үр дүнгээс огцом нэмэгдсэн байдалтай байна. 2014-2015 онуудад 26 орчим хувьтай байсан бол энэ жил 47 хувь болж 20 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тэр дундаа ХАА-ны талаарх мэдээллийн хамааралтай байдал болон эх сурвалжтай байдал өндөр хувьтай нэмэгдсэн байна.

Дүрс 21. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)



Нарийвчилсан үзүүлэлтүүдээс харвал ХАА-ны талаарх мэдээлэл тавигдсан байдал, мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлын үзүүлэлтүүд бараг өөрчлөгдөөгүй бол ХАА-ны талаарх мэдээллийн цаг үеийн байдлын үзүүлэлт 2 орчим хувиар өссөн байна.


Хүснэгт 9. Худалдан авах ажиллагааны ил тод байдлын үнэлгээ ТОП 3 (хувь)

Агентлаг	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	8.6	34.2	5.7	22.8	6.5	23.4	20.8	80.5
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	12.8	34.2	8.6	22.8	9.1	23.4	30.5	80.5
Гадаадын иргэн харьяатын газар	8.6	34.2	5.7	22.8	6.5	23.4	20.8	80.5



ХАА-тай холбоотой мэдээллийг ил тод болгосон байдлаар өмнө муу үзүүлэлттэй байсан хэрэгжүүлэгч агентлагууд 2016 онд сайн үр дүнг харуулсан байна. Дээрх хүснэгтэд харуулсан байгууллагууд нь бүгд ижил 80 дээш хувьтай байгаа нь ХАА-тай холбоотой мэдээллийг цахим хуудсаараа “бүрэн ил тод” нийтэлж байгаа хэрэг юм.

Дүрс 22. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)



Агентлагууд өөрсдийн цахим хуудастаа *тендерийн урилга, зарыг* байршуулсан байдал 2014 оны байдлаар 72.2 хувьтай байсан бол энэ жил 57.9 хувь, тендер шалгаруулалтын талаарх мэдээллийг байршуулсан байдал 33.3 хувьтай байсан бол энэ жил 15.8 хувь болж дунджаар 16 пунктаар буурчээ. *Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан /5 сая.төг-с дээш/* 2014 онд 5.6 хувьтай байсан бол энэ жил 47.4 хувь болж хамгийн их өсөөлтэй үзүүлэлтээр нэрлэгдсэн. Мөн *ХАА-нд хийсэн аудитын тайлан дүгнэлтийг* байршуулсан байдал 2014 онд 0 хувьтай байсан бол 2015 онд 10.5 хувь болж өссөн зэрэг үр дүнг харж болохоор байна. Энэ жил арга зүйд нэмэгдсэн үзүүлэлтүүд дунджаар 32.8 хувьтай үнэлэгджээ. Ялангуяа *Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга* гэсэн үзүүлэлт 78.9 хувь гэж үнэлэгдсэн байна.

## 2.3 ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 10 тохируулагч агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна. Цөмийн энергийн газар татан буугдсан учир энэ эдаагийн мониторингид хамруулаагүй байна.

Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 4 жилээр харьцуулан харуулав.

### Хүснэгт 10. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)


№	Нэрс	Нийлбэр оноо				Эрэмбэ /Ранк/			
		2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
1	Зэвсэгт хүчний жанжин штаб	20.3	14.6	29.5	44.03	68	76	83	51
2	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар	-	23.1	48.1	31.3	-	66	56	70
3	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	31.4	53.7	50.6	69.6	33	7	47	6
4	Онцгой байдлын ерөнхий газар	27.5	29.4	47.8	53.9	45	59	57	31
5	Хил хамгаалах ерөнхий газар	33.2	34.6	47.1	43.9	25	41	60	53
6	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	17	37.6	47.1	29.4	78	35	59	72
7	Стандартчилал хэмжил зүйн газар	31.8	33.5	39.9	54.4	30	44	76	29
8	Тагнуулын ерөнхий газар	29.9	26.3	35.7	25.2	38	61	78	74
9	Төрийн өмчийн хороо	35.8	52.7	56.4	0.9	18	9	27	81
10	Цагдаагийн ерөнхий газар	34	41.3	67.1	53.3	22	25	5	34
<b>Тохируулагч агентлагийн дундаж</b>		<b>27.9</b>	<b>34.1</b>	<b>46.9</b>	<b>42.4</b>				
<b>Ерөнхий дундаж</b>		<b>28.7</b>	<b>36.9</b>	<b>52.2</b>	<b>43.5</b>				

Тохируулагч агентлагуудын дундаж үзүүлэлт энэ онд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлттэй ойролцоо түвшинд байна. Харин 2015 оны судалгааны дундаж үзүүлэлтээс 4 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт 10 агентлагаас “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар” өмнөх жилийн үзүүлэлтээ 20 орчим хувиар өсгөн давтан хамгийн өндөр хувьтай үнэлэгджээ. Харин тохируулагч агентлагуудаас хамгийн муу үзүүлэлтийг “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар” харуулжээ. Энэ нь тус агентлагын нэршил, цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой байна.

Өмнөх судалгааны үр дүнгээр хангалттай оноо авч эхний 10 байранд жагсаж байсан 2 агентлаг энэ онд байр ухарсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: МХЕГ-ын цахим хуудас 2014 онд 53.7 хувиар 7-р байрт жагсаж байсан бол энэ онд 50.6 хувиар үнэлэгдэж 47-р байрт жагссан байна

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу хоёр оноор харьцуулан гаргаж өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа.


Дүрс 23. Тохируулагч агентлагуудын ил тод байдал (хувь)



2015 онд агентлагуудын 5 үзүүлэлт бүгд 1.3-3.7 пунктаар буюу дунджаар 2.5 пунктаар өссөн үр дүнг харуулж байна.

2014 онд эхний 5 байранд жагсаж байсан агентлагуудаас ЦЕГ, ТӨХ, МХЕГ-ын цахим хуудсууд эхний 5 байрт багтсан амжилтаа хадгалсан бол МТШХХГ-ын цахим хуудас 48.1 хувиар 4-р байрт, ОБГ-ын цахим хуудас 47.8 хувиар энэ онд 5-р байрт орж ирсэн байна.

Дүрс 24. Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



Тохируулагч агентлагуудын цахим хуудасны хүртээмжтэй байдал өмнөх онтой харьцуулахад 9 хувиар, хэрэглэхэд хялбар байдал нь 13.7 хувиар хувиар өссөн байна. Үүнээс дүгнэхэд цахим хуудасны хүртээмжтэй байдал нь хүртээмжгүй ангиллаас зарим

талаар хүртээмжтэй гэсэн ангилалд шилжиж. харин хэрэглэхэд хялбар байдал нь хэрэглэхэд төвөгтэй гэсэн ангилалаас хэрэглэхэд боломжтой гэсэн ангилалд шилжсэн эерэг үзүүлэлт гарсан байна.

#### Хүснэгт 11. ТОП 5 үзүүлэлттэй тохируулагч агентлагууд (хувь)


Агентлагуудын нэрс	Нийлбэр оноо	
	2015	2016
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	50.6	69.6
Станртчилал, хэмжилзүйн газар	39.9	54.4
Онцгой байдлын ерөнхий газар	47.8	53.9
Цагдаагийн ерөнхий газар	67.1	53.3
Зэвсэгт хүчний жанжин штаб	29.5	44.03

#### 2.4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл. 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

**Байгууллагын ерөнхий мэдээлэл.** Тохируулагч агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал 2014 онд дунджаар 52.8 хувь байсан бол 2015 онд 63.3 хувь болж 10.5 пунктаар дээшилсэн байна.

#### Дүрс 25. Тохируулагч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)




Өнгөрсөн жил агентлагууд *тэргүүлэх чиглэл*ээ огт байршуулаагүй байсан бол 2015 онд агентлагуудын тал хувь нь цахим хуудасдаа байршуулсан байна. Агентлагууд *үйл ажиллагааны стратеги зорилго зорилтоо* тавих байдал 31.7 хувиар буурсан байгаа бол эрхэм зорилгоо тавих байдал 13.3 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

#### Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.

Дээр хэлсэнчлэн Байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийг 2014 онд 8 үзүүлэлтээр хэмжиж байсан бол энэ онд дараах дүрсэд үзүүлсэн 11 үзүүлэлтээр хэмжсэн.

Дүрс 26. Тохируулагч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)




Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад *иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь* гэсэн үзүүлэлт 2014 онд 33.3 хувь байсан бол 2015 онд 10 хувь болж буурсан дүнтэй гарсан байна. Бусад бүх үзүүлэлт жигд 1.3-6.7 хувиар буюу дунджаар 4.1 пункпаар өссөн үзүүлэлттэй байна. Энэ жил шинээр үнэлгээнд хамруулсан үзүүлэлтүүд болох *Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг бүх агентлагууд цахим хуудасдаа байршуулсан байгаа бол Төрийн үйлчилгээ авахтай холбоотой мэдээллийн жагсаалт*-ыг 5 агентлаг байршуулсан байна.

### 2.2.5 Хүний нөөцийн ил тод байдал


тохируулагч агентлагуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. 2014 оны байдлаар агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал 27.5 хувьтай байсан бол 2015 онд 33.1 хувьтай болж 5.6 пунктаар өссөн үзүүлэлттэй байна.

**Дүрс 27. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)**




Хүний нөөцийн талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал 2014 оноос 1.5 хувиар, цаг хугацааны хувьд тохиромжтой байдал нь өмнөх онтой харьцуулахад 1.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Агентлагууд хүний нөөцийн талаарх мэдээллээ байршуулах байдал 10 хувиар өссөн нь хүний нөөцийн ил тод байдлын ерөнхий үзүүлэлт өсөлттэй гарсны гол шалтгаан болж байна.

**Дүрс 28. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)**



Албан хаагчийн ёс зүйн дүрмийг байршуулах байдал эрс нэмэгдэж 31.7 хувиар өссөн байна. Сул орон ооны талаарх мэдээллээ тавих байдал мөн нэмэгдэж 25.7 хувиар өсөлттэй гарчээ. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам байршуулсан байдал 40 хувь. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 70 хувь гэсэн үзүүлэлттэй байна.


Зураг 3. ТӨХ-ны хүний нөөцийн мэдээлэл



### 2.4.2 Төсөв санхүүгийн ил тод байдал

Тохируулагч агентлагуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдал нь өмнөх онтой харьцуулахад 21.5 пунктаар өссөн үзүүлэлттэй байна. Төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд дунджаар 10.6 пунктаар өссөн байна. Дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

Дүрс 29. Тохируулагч агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Төсөв санхүүгийн талаарх мэдээлэл оруулсан байдал нь 21.5 хувиар, эх сурвалжийн тодорхой байдал 6.3 хувиар, цаг хугацааны хувьд тодорхой байдал 4.2 хувиар өссөн байна.



**Хүснэгт 12. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)**


Агентлаг	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	27.2	38.9	18.2	26	14.3	20.4	59.7	85.3
Станртчилал, хэмжилзүйн газар	27.2	35.02	15.6	23.4	7.2	15.3	50	73.7
Онцгой байдлын ерөнхий газар	31.1	23.3	15.6	18.2	17.4	14.3	64.1	55.8

ЦЕГ-ын цахим хуудас 72.4 хувиар 1-р байрт. ТӨХ-ны цахим хуудас 70.3 хувиар 2-р барит жагссан бол 2014 онд эхний байруудад жагсаж байсан агентлагуудаас ОБЕГ-ын цахим хуудас 64.1 хувиар эхний 3 байрт багтсан амжилтаа хадгалсан байна.

**Дүрс 30. Тохируулагч агентлагуудын санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)**


Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах үзүүлэлтүүдээс төсвийн гүйцэтгэлээс бусад үзүүлэлт дунджаар 24.5 пунктаар өссөн байна. Энэ жил аргазүйд нэмж оруулсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 60 хувь. Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл 10 хувь. Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар 20 хувьтай үнэлэгдсэн байна. Бүх агентлагууд Шилэн дансны тусгай цэстэй байсан бөгөөд байгууллагын тухайн жилийн төсвөө бүгд байрлуулсан байв. Харин хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ өмнөх оноос өөрчлөлтгүй буюу 0 хувьтай байгаа нь тохируулагч агентлагууд өнгөрсөн оноос хойш энэ талаар арга хэмжээ аваагүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

**Зураг 4. ЦЕГ-ын цахим хуудас дахь төсөв, санхүүгийн мэдээлэл**



Дээрх цахим хуудасны хувьд төсвийн гүйцэтгэлийн мэдээ нь тасралгүй шинэчлэгдсэн байсан төсдийгүйшилэн дансны цахим хуудас дээрх мэдээллээ ч мөн адил өөрийн цахим хуудсанд байршуулсан байсан.

**2.4.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдал.**

Тохируулагч агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудасдаа ил тод байршуулах байдал өмнөх судалгааны үр дүнгээс нэг дахин нэмэгдсэн байна.

ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт тус бүр өссөн бөгөөд дунджаар 4.1 пунктаар нэмэгдсэн байна.

**Дүрс 30. Тохируулагч агентлагуудын ХАА-ны ил тод байдал (хувь)**



Дээрх дүрсээс харахад ХАА-ны талаарх мэдээлэл тавигдсан байдал өмнөх оны үр дүнгээс


4.2 хувиар. мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал 3.5 хувиар. мэдээллийн цаг үеийн байдал 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 13. ХАА-ны ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)**

Агентлаг	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Онцгой байдлын ерөнхий газар	12.8	21.4	8.6	14.3	9.1	10,4	30.5	46,1
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	4.3	17.1	2.9	11.4	3.9	10,4	11	38,9
Цагдаагийн ерөнхий газар	17.1	17.1	11.4	11.7	11.7	10,45	40.3	38,9

Нийт судалгаанд хамрагдсан агентлагуудаас 2 агентлаг нь 40-өөс дээш хувьтай буюу ХАА-ны талаарх мэдээлэл зарим талаар ил тод гэсэн ангилалд багтаж байна. 2014 онд ХАА-ны үзүүлэлтээр эхний байруудад жагсаж байсан ТӨХ. ЦЕГ-ууд 1.2-р байраа хадгалсан бол энэ жил ОБЕГ 2014 онд 0 хувь байсан нь 2015 онд 30.6 хувь болсон үзүүлэлтээр 3-р байрт багтсан сайгшаалтай үзүүлэлттэй байна.

**Зураг 5. ОБЕГ-ын ХАА-ны талаарх мэдээлэл**



Тохируулагч агентлагуудын ХАА-ны үзүүлэлт бусад төрийн байгууллагатай харьцуулахад 2016 оны үнэлгээнд бага хувьтай үнэлэгджээ. 2015 онд ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд бүгд дэшилсэн дэр дундаа *Тендерийн шалгаруулалтын талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй үндэслэл* зэргийг багтаасан мэдээлэл 1 дахин ихссэн байдалтай байна. Харин энэ оны үнэлгээгээр тендерийн урилга, аудитын тайлан дүгнэлт, тендер шалгаруулалт явуулах журам, тендерийн баримт бичиг зэрэг үзүүлэлтийг цахим хуудсанд ил тод болгох байдал тодорхой хувиудаар дээшилсэн байна.

Дүрс 31. Тохируулагч агентлагуудын ХАА-ны үзүүлэлт (хувь)




Тендерийн урилга. зүарын талаарх мэдээлэл 8.3 хувиар. Худалдан авсан бараа. ажил үйлчилгээний тайлан /5 сая.төг-с дээш/ 2014 онд 0 хувь байсан нь 40 хувь болж өссөн үр дүнг харж болохоор байна. 2015 онд мониторингийн арга зүйд нэмж руудсан үзүүлэлтүүдээс Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого. зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр. гүйлгээний агуулга хамгийн өндөр буюу хувьтай үнэдэгдсэн бол Тендерийн баримт бичиг. Тендер шалгаруулалт явуулах журам болон Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр/бонд. зээл. өрийн бичиг гэх мэт/ мэдээлэл огт тавигдаагүй байна. Харин Тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлтийн талаар мэдээлэл агентлагуудын 10 хувьд нь буюу 1 агентлагийн цахим хуудсанд тавигдсан байна.

## 2.4 АЙМГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт 21 аймгийн албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Зураг 6. 2014 судалгааны аймгуудын ил тод байдлын үзүүлэлт<sup>2</sup>



2014 оны судалгааны үр дүнгээр ихэнхи аймаг улаан өнгөтэй буюу 40-өөс хувьтай байсан бол 2015 онд 40-өөс доош хувьтай ганцхан Дархан-Уул аймаг л дүгнэгдсэн байна. Харин эсрэгээр 2014 онд 60-80 онооны хооронд дүгнэгдсэн амжилттай ганц Говь-алтай аймаг байсан бол энэ оны судалгаагаар Дорнод, Өвөрхангай, Говь-Алтай, Баян-Өлгий гэсэн 4 аймаг бусдаасаа өндөр хувьтай гарчээ.

Аймгуудын цахим хуудсуудын 2015 оны судалгааны үр дүнг нийлбэр оноогоор 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 14. Аймгуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Нэрс	Нийлбэр оноо				Эрэмбэ /Ранк/			
		2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
1	Архангай	19.9	22.4	53.7	51.5	69	68	39	39
2	Баянхонгор	-	41.9	56.2	83.8	-	23	28	1
3	Баян-Өлгий	23.6	54.4	61.2	57.7	59	6	15	18
4	Булган	26.3	31.5	51.3	20	49	52	46	75
5	Говь-Алтай	22.2	70.8	60.3	32.3	63	1	17	68
6	Говьсүмбэр	37.4	26.1	56.6	58.5	14	62	25	20
7	Дархан-Уул	17.7	41.9	33.8	57.7	76	23	81	22
8	Дорноговь	21.6	55.6	43.9	17.7	65	4	72	77
9	Дорнод	-	53.5	64.5	70.7	-	8	12	6
10	Дундговь	15.6	41.6	52.9	43.8	80	24	40	53
11	Завхан	30.7	32.9	57.6	53	35	46	22	37
12	Орхон	-	56.5	65.3	75.4	-	3	10	2
13	Өвөрхангай	29.1	22.1	60.4	38.5	42	70	16	59
14	Өмнөговь	31.2	40.7	45.8	36.9	34	28	66	61
15	Сүхбаатар	28.6	22.2	-	69.2	44	69	-	8
16	Сэлэнгэ	26.4	39	54.9	47.7	48	32	33	45
17	Төв	28.6	32.4	50.5	46.1	44	49	48	47
18	Увс	32.8	41.1	55.2	35.4	26	26	31	64
19	Ховд	10.7	35.9	45.3	44.6	84	39	69	49
20	Хөвсгөл	29.2	54.7	57.5	40.7	41	5	23	57

<sup>2</sup>0-40 оноог улаанаар, 41-60 оноог шараар, 61-80 оноог ногооноор тэмдэглэв. 81-ээс дээш оноо цэнхэр байх хэдий ч одоогоор тийм шалгуур хангасан аймаг байхгүй байна.

21	Хэнтий	-	34.5	52.1	59.2	-	42	43	19
<b>Аймгийн дундаж</b>		<b>25.1</b>	<b>40.9</b>	<b>54</b>	<b>49.6</b>				
<b>Ерөнхий дундаж</b>		<b>28.7</b>	<b>36.9</b>	<b>52.2</b>	<b>46.1</b>				

Аймгуудын цахим хуудасны ил тод байдлын дундаж үзүүлэлт 2015 онд 52,2 хувь байгаа нь 2014 оны үр дүнгээс 13 орчим хувиар өссөн, энэ оны ерөнхий дундажаас 2 орчим хувиар өндөр байгааг илтгэж байна.

Аймаг тус бүрээр үзүүлэлтийг харвал ихэнхи аймгуудын цахим хуудсын ил тод байдлын дундаж үзүүлэлтүүд өсөлттэй үр дүнтэй байна. Харин Говь-Алтай болон Дархан-Уул аймгийн цахим хуудсын үзүүлэлт өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 8-10 орчим хувиар буурсан байдалтай харагдаж байна.

#### Хүснэгт 15. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь)


Аймгуудын нэрс	Нийлбэр хувь			
	2011	2014	2015	2016
Баянхонгор	-	41.9	56.2	83.08
Орхон	-	56.5	65.3	74.6
Дорнод	-	53.5	64.5	70
Сүхбаатар	28.6	22.2	-	69.2
Хэнтий	-	34.5	52.1	59.2

Өндөр хувьтай дүгнэгдсэн цахим хуудсуудаар Орхон, Дорнод, Баян-өлгий, Өвөрхангай, Говь-алтай зэрэг аймгийн үзүүлэлтийг нэрлэж болох бөгөөд “ил тод” гэсэн ангилалд багтааж авч үзэж болохоор байна.

Эсрэгээр 40-өөс доош хувьтай буюу цахим хуудсын мэдээлэл нь “хаалттай” гэсэн ангилалд Дархан-Уул аймгийн цахим хуудас орж сөрөг үр дүнг харууллаа.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтээр нь задлаад хоёр оноор харьцуулан гарсан өөрчлөлтийг дараах графикт харууллаа.

#### Дүрс 32. Аймгуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)




2015 онд аймгуудын цахим хуудсын ил тод байдлыг илтгэх 5 үзүүлэлтийн нийлбэр хувь 54 байгаа нь 2014 оныхоос 13 орчим хувиар өссөн үзүүлэлт юм. Дээрх 5-н үзүүлэлтийн 4 нь 2014 оны судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр өссөн байгаа бол цахим хуудсын хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт бага зэрэг буурсан байдалтай харагдаж байна.

### Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал

Цахим хуудсыг хэрэглэх байдлыг тооцоходоо цахим хуудсын хүртээмжтэй байдал болон хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлтүүдээр тус тус тооцсон болно.

Дүрс 33. Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



Мэдээллийн хүртээмжтэй байдлыг 5 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд хэлний сонголт болон асуулт хариулт, хэлэлцүүлгийн булан аймгийн цахим хуудсуудад маш хангалтгүй байна. Харин хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт 2015 онд 71,8 хувь байгаа нь 2014 оны судалгааны үр дүнгээс 3 орчим хувиар буурсан байгаа илтгэж байна.

#### 2.4.1 Үйл ажиллагааны ил тод байдал


Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ байгууллагын талаарх 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

#### **Байгууллагын ерөнхий мэдээлэл.**

Байгууллагын ерөнхий мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан эсэхийг үндсэн 3-н асуултаар шалгаж үзэхэд 45 хувьтай байгаа нь 2014 оны үзүүлэлттэй харьцуулахад 12 орчим хувиар өссөн байна.



Дүрс 34. Аймгуудын ерөнхий мэдээлэл (хувь)



Байгууллагын эрхэм зорилгыг 20 хувь нь, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг 90 хувь нь, тэргүүлэх чиглэлээ 19 хувь нь цахим хуудсандаа байршуулсан байгаа нь дээрх дүрсээс харагдаж байна. Байгууллагын эрхэм зорилгыг цахим хуудсандаа байршуулах байдал 20 хувь болж 2014 оны үр дүнгээс буурсан, тэргүүлэх чиглэл нь 25 хувьд нь мэдээлэгдсэн байгаа нь хангалтгүй үзүүлэлтийг харуулж байна.


**Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.**

Олон нийттэй харилцах чиглэлийн мэдээлэл аймгуудын цахим хуудсанд тавигдсан эсэхийг судлахдаа нийт 10 үзүүлэлтийг шалгуур болгон авсан нь 2014 оны судалгаанаас 2-н үзүүлэлтээр илүү байгаа юм.



Тэдгээр үзүүлэлтийн үр дүнгүүдээ 2014 оын үр дүнтэй харьцуулан дараах дүрсээр илэрхийллээ.

Дүрс 35. Аймгуудын цахим хуудасны олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)




Олон нийттэй харилцах мэдээллийн цахим хуудсанд мэдээлэгдсэн байдлын хувийг дундажлан харвал 35 хувь байгаа нь 2014 оны дундажтай ижил үзүүлэлт болж байна. Байгууллагын хаяг, цахим шуудангийн хаяг, факсын дугаар, шуудангийн хаяг зэрэг ихэнхи үзүүлэлт нь 2015 онд өмнөх судалгааны үр дүнгээс буурсан байна. Харин байгууллагатай холбоо барих утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хувиар гэсэн 2 үзүүлэлт нэлээд хэмжээгээр өссөн нь дундаж хувийг хадгалж үлдэхэд нөлөөлсөн байна. Шинээр нэмэгдсэн 2 үзүүлэлтийн хувьд “байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм журам” 95 хувьтай, “төрийн үйлчилгээ авахтай холбоотой мэдээллийн жагсалт” 60 хувьтай байгаа нь бусад үзүүлэлтээсээ өндөр үр дүнг харуулж байна.

## 2.4.2 Хүний нөөцийн ил тод байдал

Аймгуудын цахим хуудасны хүний нөөцийн мэдээлэлд гол төлөв төрийн жинхэнэ албаны мэргэшлийн болон нөөцийн судалгаа тавигдсан байсан. Тиймээс энэ үзүүлэлтийг тус судалгаа болон сул орон тоог нөхөх зар тавигдсан эсэх байдлаар үнэлсэн.

Дүрс 36. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)




Аймгуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал 52,4 хувь байгаа нь өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 23 орчим хувиар өссөн байна. Шалгуур тус бүрээр авч үзвэл хүний нөөцийн талаарх мэдээллийн найдвартай байдал нь 30-аас 22,3 оноо, тухайн мэдээллийнхээ найдвартай байдлыг хангасан байдал 20-оос 12,9 оноо, цаг хугацааны хувьд тохирсон, тодохой бадал нь 20-оос 17,2 хувьтай байна. Хүний нөөцийн талаарх мэдээллээ цахим хуудсаараа мэдээлэлдэг байдлын хувиар эхний 3-н аймгийг эрэмбэлж доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 16. Хүний нөөцийн ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)

Аймгийн нэрс	Мэдээлэл байгаа эсэх				Эх сурвалж тодорхой эсэх				Цаг хугацаа нь байгаа эсэх			
	2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
Баян-Өлгий			25.7	42.8			28.6	28.6			28.6	28.6
Баянхонгор			25.7	42.8			28.6	28.6			28.6	28.6
Сэлэнгэ			34.2	34.2			28.6	28.6			28.6	28.6

Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр Өмнөговь аймаг бусдаасаа өндөр үнэлгээ авсан байна. Бусад Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ гэсэн 3-н аймаг ижил оноотойгоор 2-4-р байранд орсон байна.

Дүрс 37. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)



Дээрх дүрсээс харахад 2015 судалгааны үр дүнгээр аймгуудын цахим хуудсанд хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдалд өсөлт гарсан байна.

Зураг 7. Өмнөговь аймгийн цахим хуудас дахь хүний нөөцийн мэдээлэл

**ӨМНӨГОВЬ АЙМАГ**  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хүний нөөцийн ил тод байдал  
2013-10-11

Сүүлд нэмэгдсэн


Өмнөговь аймаг	Хүний нөөцийн ил тод байдал
2013-10-11	30
2014-05-11	33.3
2015-05-11	70
2016-05-11	14.3

Дээрх зурагт харуулснаар Өмнөговь аймгийн цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээлэл 100 хувь бүрэн үзүүлэлттэй гарсан бөгөөд бусад аймгуудын хувьд холбогдолтой, найдвартай, цаг хугацааны байдлууд дээрээ ямар нэгэн байдлаар дутуу мэдээллэсэн нь харагдаж байна. 2014 оны судалгааны үр дүнгээр хүний нөөцийн холбогдолтой мэдээлэл огт байхгүй 12 аймаг байсан бол 2015 оны судалгааны үр дүнгээр Архангай, Завхан, Ховд гэсэн 3 аймаг энэхүү хангалтгүй үзүүлэлтээ давтжээ.

### 2.4.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Аймгуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг дараах дүрсэд харуулья.

Дүрс 38. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Аймгуудын цахим хуудасны төсөв, санхүүгийн ил тод байдлын үр дүнг харуулсан дээрх дүрсээс харахад мэдээллийн холбогдолтой байдал 30-аас 27,5 оноо, тухайн мэдээллийн эх сурвалж тодорхой байдал 20-оос 16,7 оноо, тухайн мэдээллийн цаг хугацааны тохиромжтой байдал 20-оос 16,6 оноо тус тус авсан байгаа нь 1014 оны үр дүнгээс нэлээд өсөлтийг бий болгожээ.

Хүснэгт 17. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 аймаг (хувь)

Аймгийн нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодор-хой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Баян-Өлгий	28.1	42.8	19.06	7.8	13.7	28.6	61.3	79.2
Баянхонгор	32.1	42.8	21.4	28.6	18.7	20.4	72.2	91.8
Сүхбаатар	-	35.02	-	23.4	-	22.5	-	80.9

Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээгээр өндөр үзүүлэлттэй гарсан 3-н аймгийг жагсааж дээрх хүснэгтээр илэрхийллээ. Энэ үзүүлэлтээр 70-аас дээш хувьтай 6-н байгууллага байгаа бол 2014 онд 70-аас дээш хувьтай 2 байгууллага байсан нь эерэг өөрчлөлт гарсныг илтгэж байна.

Дүрс 39. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)



Төсөв санхүүгийн ил тод байдлын үр дүнгүүдээс 2014 онд ашиглагдаж байсан үзүүлэлтүүдийн хувь маш сайн нэмэгдэж “бүрэн ил тод” гэсэн ангилалд бүгд багтсан байна. Харин энэ жилээс шилэн дансны хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинээр нэмэгдсэн үзүүлэлтийн хувьд, шилэн дансны тусгай цэс 90 хувьтай, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 90 хувьтай мэдээлэгдсэн байгаа нь нэлээд сайн үр дүнг илэрхийлж байна.


Харин төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллүүд нь бага хувиар аймгийн цахим хуудсуудад мэдээлэгдэж байгаа нь харагдаж байна.

#### 2.4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Аймгуудын ХАА-ны тухай мэдээлэл тухайн аймгийнхаа албан ёсны цахим хуудаст цаг тухай бүрт нь байршиж байх нь ихээхэн чухал. Өмнө нь өгүүлсэнчлэн хэдийгээр төрийн байгууллагын ХАА-ны талаарх мэдээллийг түгээдэг тусдаа цахим хуудас байгаа хэдий ч

бид өмнөх арга зүйгээ баримтлан тухайн байгууллагын цахим хуудсанд мэдээлэх ёстой гэж үзсэн.

Дүрс 40. Аймгуудын цахим хуудасны ХАА-ны ил тод байдал (хувь)



Дээрх дүрсэд харуулснаар ХАА-ны талаарх мэдээлэл мэдээлэгдсэн байдал 30-аас 24,8 оноо, тус мэдээллийн эх сурвалж байгаа эсэх нь 20-оос 15,6 оноо, цаг хугацааны хувьд тодорхой, тохиромжтой байгаа эсэх нь 20-оос 12,1 байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад өсөлттэй үр дүнг харуулж буй юм.

Цаг хугацааны хувьд тохирсон байдал нь 12,1 байгаа нь бусад үзүүлэлттэй харьцуулахад арай бага үр дүнг илэрхийлж байна.

ХАА-ны ил тод байдлаар сайн үр дүн үзүүлсэн аймгуудыг доорх хүснэгтэд харууллаа


Хүснэгт 18. ХАА-ны ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)

Аймгийн нэрс	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Баянхонгор	17	38	6	26	12	22	34	86
Говьсүмбэр	26	38	17	26	13	22	56	86
Орхон	30	34	17	23	18	22	65	79
Сүхбаатар	-	34	-	23	-	22	-	79

ХАА-тай холбоотой мэдээ мэдээлэл аймгуудын цахим хуудсанд бүхий л үзүүлэлтийн хувьд өсөлттэй үр дүнг үзүүлж байна.



Дүрс 41. Аймгуудын ХАА-ны ил тод байдал (хувь)



Тендерийн урилга болон тендер шалгаруулалтын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах байдал “ил тод” гэсэн ангилалд хамаарахуйц өндөр үзүүлэлттэй байна. Мөн 2014 оны судалгаагаар 0 хувьтай байсан “ХАА-нд хийсэн аудитын дүгнэлт, хяналт шалгалтын дүн” 2015 оны судалгаагаар 65 хувь болтолоо өссөн байна.

Энэ оны судалгаанд нэмэгдэн орж ирсэн үзүүлэлтүүдээс “тендерт оролцохыг сонирхогчидод тавигдах шалгуур үзүүлэлт”-ийг нийтэлсэн байдал 80 хувьтай сайн үр дүнг үзүүлж байна. Эсрэгээр “тендер шалгаруулалт явуулах журам”, “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын талаарх мэдээлэл”, “мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, зэрэг үзүүлэлтүүд хангалтгүй хувьтай нийтлэгдэж байна.


“Тендерийн жишиг баримт бичиг” 2015 оны судалгааны үр дүнгээр огт мэдээлэгдээгүй нь харагдаж байна.

## 2.5 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт НДТГ-ын цахим хуудас, УБ хотын захирагчийн ажлын албаны цахим хуудас болон 9 дүүргийн ЗДТГ-ын цахим хуудсыг хамруулсан болно.

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

**Зураг 8. Дүүргүүдийн ил тод байдлын үзүүлэлт<sup>3</sup>**



Энэ бүлэгт хамаарах нийт 11 цахим хуудсаас 2014 онд 1 дүүргийн цахим хуудас ил тод, 4 цахим хуудас зарим талаар ил тод, 6 дүүргийн цахим хуудас хаалттай ангилалд багтаж байсан бол энэ онд 2 дүүрэг, УБ хотын захирагчийн ажлын албаны цахим хуудас ил тод, бусад 8 цахим хуудас нь зарим талаар ил тод, 1 дүүргийн цахим хуудас хаалттай гэсэн ангилалд хамаарч байна.

Үүнээс дүгнэхэд ил тод цахим хуудасны тоо 2-оор нэмэгдэж, харин 1 цахим хуудас үзүүлэлттээ өсгөж хаалттай ангиллаас зарим талаар ил тод ангилалд шилжиж, 1 дүүрэг хаалттай цахим хуудастай хэвээр байна.

**Хүснэгт 19. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)**


№	Дүүргүүдийн нэрс	Нийлбэр оноо				Эрэмбэ /Ранк/			
		2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
1	НЭДТГ	-	40.9	57.3	55.8	-	27	24	27
2	УБ хотын захирагчийн ажлын алба	-	22.6	62.7	60.4	-	67	14	17
3	БГД-ийн ЗДТГ	-	43.4	67	39.4	-	21	6	58
4	БХД-ийн ЗДТГ	-	22.1	39.5	55.2	-	70	77	28
5	БЗД-ийн ЗДТГ	-	30.5	55.2	49.4	-	56	32	41
6	БНД-ийн ЗДТГ	-	25.4	59.4	54.4	-	64	20	32
7	ЧД-ийн ЗДТГ	-	39.6	54.6	54.6	-	30	36	30
8	СБД-ийн ЗДТГ	-	34	49.5	70.4	-	43	50	4
9	СХД-ийн ЗДТГ	-	39.2	48.7	48.3	-	31	54	44
10	ХУД-ийн ЗДТГ	-	20.1	65.8	60.8	-	72	9	16
11	НД-ийн ЗДТГ	-	31.1	54.9	56.6	-	53	34	24
<b>Нийслэлийн дундаж</b>		-		<b>55.9</b>	<b>55</b>	-			
<b>Ерөнхий дундаж</b>		-		<b>52.2</b>	<b>46.2</b>	-			

Нийслэлийн захиргаа дүүргүүдийн цахим хуудасны дундаж үзүүлэлт энэ онд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 3.3 пунктаар өндөр түвшинд байна. Бүх цахим хуудасны ил тод байдлын хувь өссөн бөгөөд дундаж үзүүлэлтийг харьцуулж үзэхэд өмнө оноос 24.2 пунктаар өссөн үзүүлэлттэй байна. 2014 онд эхний 20 байранд багтсан цахим хуудас энэ бүлэгт байгаагүй бол энэ онд 3 цахим хуудас эхний 20 байранд багтсан үр дүн гарсан байна. Тухайлбал: БГД-ийн цахим хуудас 2014 онд 43.4 хувь 21-р байраас 2015 онд

<sup>3</sup>0-40 оноо улаан өнгөөр, 41-60 оноог шар өнгөөр, 61-80 оноог ногоон өнгөөр тэмдэглэсэн.

67 хувиар 2-р байрт. ХУД-ийн цахим хуудас 2014 онд 20.1 хувь 42-р байрт байсан бол 2015 онд 65.8 хувиар 9-р байр луу урагшилсан байна.

**Дүрс 42. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)**



Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал өмнөх онтой харьцуулахад 15 пунктаар нэмэгдсэн байна. Энэ бүлэгт хамаарах цахим хуудсуудын үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад *мэдээллийн хамааралтай байдал* 11.8 хувиар, *мэдээллийн найдвартай байдал* 5.5 хувиар, *мэдээллийн хүртээмжтэй байдал* 4.2 хувиар өссөн бол *хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт* 3.1 хувиар, *мэдээллийн цаг үеийн байдал* 3.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үндсэн 5 үзүүлэлтийн зарим нь өссөн, зарим нь буурсан харагдаж байгаа ч 2014 онд дундаж үзүүлэлт 8.2 хувь байсан бол 2015 дундаж үзүүлэлт 11.1 хувь болж өмнөх оноос 2.9 пунктаар өссөн байна.

**Хүснэгт 20. Нийслэлийн захиргаа, дүүргийн ТОП 5 байгууллага**

Дүүргүүдийн нэрс	2015	2016
СБД-ийн ЗДТГ	49.5	70.4
ХУД-ийн ЗДТГ	65.8	60.8
УБХЗ-ийн ажлын алба	62.7	60.4
НД-ийн ЗДТГ	54.9	56.6
Улаанбаатар хотын ЗДТГ	57.3	55.8



2016 онд эхний 5 байранд багтсан байгууллагуудаас Хан-Уул дүүрэг, УБХЗ-ийн ажлын алба зэрэг байгууллагуудын цахим хуудас амжилтаа хадгалан 2-3 дах жилдээ топ үзүүлэлттэй байгууллагаар шалгарсан байна.


**2.5.1 Үйл ажиллагааны ил тод байдал**

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

**Байгууллагын ерөнхий мэдээлэл** Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад энэ бүлэгт хамрагдсан нийт цахим хуудсуудын

танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал 18.2-54.5 хувиар буюу маш өндөр өсөлттэй үр дүн гарсан байна.

**Дүрс 43. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)**




Бусад төрийн байгууллагуудын цахим хуудастай харьцуулахад тэргүүлэх чиглэлийн мэдээллийг байршуулсан байдал хамгийн өндөр хувиар буюу 54.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эрхэм зорилго болон үйл ажиллагааны стратеги зорилго, зорилтын мэдээллээ 90.9 хувьтай байршуулсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 18.2

**Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.**

Дээрх үр дүнгээс харахад байгууллагууд тэргүүлэх чиглэлээ цахим хуудас дээрээ байршуулах байдал нь өмнөх судалгааны үр дүнгээс даруй 42.1 хувь, үйл ажиллагааны стратеги зорилго зорилтоо тавих байдал 6.7 хувиар өссөн байгаа бол эрхэм зорилгоо тавих байдал 28.4 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

Дүрс 44. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн олон нийттэй харилцахтай холбоотой мэдээлэл (хувь)




Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хувьд өмнөх жилийн мониторингид шинээр нэмэгдсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад байгууллагын олон нийттэй харилцах мэдээллийн үзүүлэлтүүд бүгд өссөн дүнтэй тэр дундаа *байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам зааврыг* байршуулсан байдал 81.8 хувиар өссөн байна. Нэг сонирхолтой үр дүн гарсан нь байгууллагын олон нийттэй харилцахтай холбоотой үзүүлэлтүүдээс 3 үзүүлэлт өмнөх оны байдлаасаа огт өөрчлөлтгүй гарсан байв. *Байгууллагын хаяг* 2014 онд 100 хувь байсан бол энэ онд мөн адил. *Үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт* 2014 онд 63.6 хувь байсан нь энэ онд мөн адил. мөн *шуудангийн хаягийн* мэлээлэл 2014 онд огт байршаагүй байсан нь энэ онд мөн нэмэгдээгүй 0 хувьтай байна. Нийт үзүүлэлтүүдийн өсөлтийн хувийг 2014 онтой харьцуулахад дунджаар 27.1 пунктаар өссөн.

### 2.5.2 Хүний нөөцийн ил тод байдал


Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. 2014 оны байдлаар эдгээр цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал 24.7 хувьтай байсан бол 2015 онд 48.8 хувьтай болж 24.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрс 45. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)



Хүний нөөцийн талаарх мэдээлэл байршуулсан байдал 20.2 хувиар нэмэгдсэн ч цаг хугацааны хувьд тохирсон, тодорхой байдал нь 1.3 хувиар буурсан байна. Харин эх сурвалжийн тодорхой байдал яг нэг дахин нэмэгдсэн үр дүн гарсан байна.

Дүрс 46. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)



2014 онд нийслэлийн захиргаа, дүүргүүд сул орон тооны талаарх мэдээллээ дөнгөж 11.7 хувьтай ил тод байршуулж байсан бол энэ онд 54.5 хувь болж 42.8 хувиар өссөн эерэг үр дүн гарсан байна. Энэ жил шинээр нэмсэн *Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам*, *Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл* зэрэг нь ижил 81.8 хувьтай үнэлэгдсэн байна.

**Хүснэгт 21. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 дүүрэг (хувь)**

Дүүргүүдийн нэрс	Мэдээ-лэл эсэх байгаа		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
НД-ийн ЗДТГ	42.8	25.7	28.6	28.6	14.3	28.6	85.7	82.8
СБД-ийн ЗДТГ	8.6	17.1	0	28.6	0	28.6	8.6	74.3
УБ хотын ЗДТГ	34.2	17.1	0	28.6	14.3	28.6	48.5	74.3
ЧД-ийн ЗДТГ	34.2	17.1	0	28.6	0	28.6	34.2	74.3
Нийт дундаж	31.9	14.8	10.4	10.4	6.5	10.4	48.8	35.6


2014 онд эхний 3 байранд жагсаж байсан цахим хуудсуудаас НД-ийн цахим хуудас энэ амжилтаа хадгалсан байна. ХУД-ийн цахим хуудас хүний нөөцийн ил тод байдлын шаардлагаыг бүрэн хангаж 100 хувь гэж үнэлэгдэн. Харин БНД-ийн цахим хуудас бусад үзүүлэлтээр сайнгүй байсан ч хүний нөөцийн ил тод байдлын хувьд 48.8 хувьтай үнэлэгдэж 3-р байрт жагссан. Дээрх 3 цахим хуудсуудын мэдээлэл байршуулсан байдал. эх сурвалжийн тодорхой байдал зэрэг нь бараг ижилхэн байсан бөгөөд цаг хугацааны хувьд тохирсон . тодорхой байдлаараа их бага оноо авч ийнхүү эрэмбэлэгдсэн билээ.

**Зураг 9. ХУД-ийн хүний нөөцийн ил тод байдал**


ХУД-ын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын цэс нь сул орон тооны зараас гадна хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, дүрэм журам гэсэн хэсгүүдтэй. Түүндээ шинээр зэрэг дэв олгосон албан хаагчдын жагсаалт, төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх журам, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх хуудас дүүргийн тамгын газрын хэлтэс тасгуудын дүрэм, журам зэргийг оруулсан байна.

**2.5.3 Төсөв санхүүгийн ил тод байдал**

Энэ онд нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын хувь өмнөх оноос 40.3 пунктаар өссөн байна. Ингэж өндөр хувиар өссөн нь энэ жил тухайн байгууллагын вебсайт шилэн дансны тусгай цэстэй байвал тухайн цэсээр дамжин орж төсөв, санхүүгийн талаарх мэдээлэлд мониторинг хийсэнтэй холбоотой юм.




**Дүрс 47. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)**





Дээрх дүрсэд харагдаж байгаачлан мэдээллийн эх сурвалжийн тодорхой байдал хамгийн өндөр хувиар буюу 15.9 хувиар өссөн байна. Төсөв санхүүгийн талаарх мэдээллийн эх сурвалжийн тодорхой байдал өсөлттэй гарахад үзүүлсэн томоохон мэдээлэл нь шилэн дансны цэс дээр тухайн мэдээллийг хариуцсан буюу төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн эрх баригчийн нэр, байгууллагаын дарга, нягтлан бодогчийн нэр, утас зэрэг мэдээлэл байсантай холбоотой. Мөн тухайн мэдээллийн доор **энэхүү мэдээлэлтэй холбоотой тодруулгыг доорх хаягаар холбогдож авна уу?** гэсэн бичиг байгаа нь төсөв санхүүгийн мэдээлэлд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлж өгсөн зүйл байв.

**Дүрс 48. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)**



Төсөв санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хувьд энэ жил бүгд өсөлттэй гарсан. Тухайлбал 2014 онд огт байршуулаагүй байсан тухайн жилийн төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл энэ жил 18.2 хувьтай тавигдсан байна. Энэ жилийн мониторингийн судалгааны нэг онцлог нь шилэн дансны тусгай цэсээр дамжин орж төсөв санхүүгийн талаарх мэдээлэлд шинжилгээ хийх байсан. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудаснууд бүгд шилэн дансны тусгай цэстэй байсан бөгөөд холбоосууд нь бүгд ажиллагаатай байв. Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл бусад бүлэгт хамаарах төрийн байгууллагуудаас харьцангуй өндөр үзүүлэлт гарчээ.



**Хүснэгт 22. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 нийслэл, дүүрэг(хувь)**

Дүүргүүдийн нэрс	Мэдээ-лэл эсэх байгаа		Эх сурвалж тодор-хой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
ХУД-ийн ЗДТГ	32.1	42.8	21.4	26	23.7	25.5	77.2	94.3
НД-ийн ЗДТГ	32.1	38.9	21.4	23.4	19.9	22.5	73.5	84.8
СБД-ийн ЗДТГ	14.3	38.9	9.5	23.4	7.5	22.5	31.3	84.8
Нийт дундаж	25.9	33.6	16.7	21.3	14.5	20.6	57.1	75.5

Энэ жилийн хувьд нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтээр эхний 3 байранд жагсаж байсан цахим хуудсуудаас БГД-ийн цахим хуудас амжилтаа хадгалсан төдийгүй дээшлүүлж төсөв санхүүгийн хувьд хамгийн ил тод цахим хуудсаар нэрлэгдсэн байна.

**Зураг 10. БГД-ийн төсөв, санхүүгийн ил тод байдал**


Төсөв санхүүгийн талаарх мэдээллүүд зохих ангиллын хувьд тавигдсан байгаагаас гадна мэдээллүүдийг татаж авч ашиглах боломжтой. тайлан гүйцэтгэлээ тогтмол шинэчилсэн. шилэн дансны хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллээ мөн байршуулсан байв.




**2.5.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал**

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны хувьд худалдан авах ажиллагааны ил тод байдал хаалттай ангиллаас зарим талаар ил тод ангилал руу шилжсэн байна.

Дүрс 49. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)



Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудасдаа байршуулахдаа тухайн тендерийн ерөнхий мэдээллийг тавихаас гадна хүлээн авах, нээх газар, цаг хугацаа, хүлээн авах хүний нэрийг бичиж буй байдал нэмэгдсэн нь ХАА-ны мэдээллийн эх сурвалж тодорхой байдлыг 8.2 хувиар өсгөсөн үзүүлэлт болж байна. Цаг хугацааны хувьд тохирсон, тохиромжтой байдал их биш ч гэсэн тодорхой хувиар өссөн байна. Нийслэлийн захиргаа, дүүргүүд өөийн цахим хуудасдаа ХАА-ны талаарх мэдээллээ оруулахдаа оруулсан цаг хугацааг тавих байдал сайнгүй байсан боловч шилэн дансны тусгай сайт дахь мэдээллийн доор тухайн мэдээллийг оруулсан хугацааг тавьсан байгаа нь мэдээллийн цаг хугацааны хувьд тодорхой, тохиромжтой байдлыг нэмэгдүүлсэн.

**Дүрс 50. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)**


2015 онд ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд бүгд өссөн үзүүлэлтийг харуулж байна. Энэ бүлэг дэх байгууллагууд цахим хуудасдаа доод тал нь 1 тендерийн урилгыг байршуулсан байсан. Тендер шалгаруулалтын талаарх ерөнхий мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн нэр, шалтгаан зэргийг байршуулсан байдал өмнөх оноос 1 дахин буюу 18.2 хувиар өсөж 36.4 хувьтай байсан бол 5 сая төг-өөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын талаарх мэдээлэл мөн хувьтай үнэлэгдсэн байна. Энэ жил нэмэгдсэн дэд үзүүлэлтүүд бүгд 70-аас дээш хувьтай байгаа нь нийслэлийн захиргаа, дүүргүүд шилэн дансны тусгай сайтад мэдээллээ тогтмол шинэчлэн байрлуулж байгааг харуулж байна.


**Хүснэгт 23. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал ТОП 2 (хувь)**

Дүүргүүдийн нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодор-хой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
СБД-ийн ЗДТГ	21.4	34.2	14.3	22.8	11.7	22.1	47.4	79.2
УБ хотын ЗДТГ	21.4	34.2	14.3	22.8	9.1	22.1	44.8	79.2
ЧД-ийн ЗДТГ	21.4	34.2	14.3	22.8	7.8	22.1	43.5	79.2
Нийт дундаж	22.6	23	14.3	15.3	11.2	13.3	48.1	51.6

ХАА-ны ил тод байдлын үнэлгээгээр Хан-Уул дүүргийн цахим хуудас 64.3 оноогоор хамгийн ил тод гэж үнэлэгдсэн байна. Энэ үзүүлэлт нь нийслэлийн захиргаа, дүүргүүдийн бусад цахим хуудастай харьцуулахад сайн үзүүлэлт хэдий ч бүрэн ил тод биш ил тод гэсэн ангилалд багтах үзүүлэлт юм. Эхний 2 байрт багтсан дээрх цахим хуудсууд энэ бүлгийн цахим хуудасны дундаж үзүүлэлтүүдээс ХАА-ны талаарх мэдээлэл байгаа байдлаар 3.9-8.2 хувиар илүү. ХАА-ны эх сурвалж тодорхой

байдлаар 3.1-6 хувиар өндөр. ХАА-ны талаарх мэдээлэл цаг хугацааны хувьд тохирсон байдлаар 5 хувиар тус тус өндөр үзүүлэлттэй байгаа юм.

**Зураг 11. ЧД-ийн ХАА-ны ил тод байдал**



Хан-Уул дүүргийн цахим хуудасны хувьд ХАА-ны талаарх мэдээллүүд ХАА-ны төлөвлөгөө, зарлагдсан тендер, тендерийн нээлт, үр дүн гэсэн ангиллын дагуу фолдерлон оруулсан байсан. Тендерийн нээлт гэсэн хэсэгт 60 орчим тендерийн нээлт болон түүнтэй холбоотой багц мэдээллүүдийг багтаасан байсан.

## 2.6 ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэхүү бүлэгт парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээг харуулна.

Байгууллага бүрийг 2014 болон 2015 оны судалгааны үр дүнгээр харьцуулан, дундаж хувийг ерөнхий төрийн байгууллагуудын дундажтай харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.


Хүснэгт 24. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)

№	Байгууллагын нэрс	Нийлбэр оноо				Эрэмбэ /Ранк/			
		2011	2014	2015	2016	2011	2014	2015	2016
1	ТАЗ	40.9	36.5	46.4	33.5	7	38	62	67
2	АТГ	31.5	32.9	58.5	44.8	32	46	21	49
3	СЗХ	30.7	35.2	48.9	36.7	35	40	51	62
4	СЕХ	19	46.1	73.3	41.1	72	16	2	57
5	ХЭҮК	27.1	48	45.9	37.2	46	13	65	61
6	ҮАГ	35.1	40	44.7	22.9	20	29	71	75
7	ҮСХ	40.6	45.3	47.3	31.3	10	18	58	69
8	Монгол банк	35.1	37.6	66.5	48.5	19	35	7	42
9	УИХ	23.8	32.6	52	33.8	58	48	44	65
<b>Парламентын байгууллагын дундаж</b>		<b>28.8</b>	<b>39.3</b>	53.7	42.4				
<b>Ерөнхий дундаж</b>		<b>28.7</b>	<b>36.9</b>	52.2	43.5				

Парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасуудын дундаж нь 53,7 хувьтай байгаа нь ерөнхий дундажаас 1,5 хувиар, өмнөх жилийн үр дүнгээс 14 орчим хувиар өссөн үзүүлэлт юм. Судалгааны үр дүнгээр 40 хувиас доош үнэлгээтэй буюу “бүрэн хаалттай” гэсэн ангиалалд хамаарах цахим хуудас байхгүй болсон ч ТАЗ, ҮАГ, ХЭҮК зэрэг газрууд цаашид ч гэсэн цахим хуудасны ил тод байдлаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Парламентын байгууллагуудын цахим хуудасуудын ил тод байдлыг хэмжиж буй 5-н үзүүлэлт тус бүрээр үр дүнг 2 оноор харьцуулан дор харууллаа.

Дүрс 51. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)



Цахим хуудсыг хэмжиж буй 5-н шалгуур үзүүлэлт бүгд өсөлттэй үр дүнг харуулж байна. Ялангуяа мэдээллийн найдвартай байдал 2014 оны судалгааны үр дүнгээр 20 онооноос 0,2 –ыг авч байсан бол, 2015 оны судалгаагаар 7,9 болж нэлээд өсөлттэй үр дүнг үзүүлжээ. Бусад 4-н үзүүлэлтийн хувьд тус бүртээ 1-3 функтаар өссөн байгааг дээрх хүснэгтээс харж болохоор байна.


Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлыг 2 оноор харьцуулж харвал, цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал 94,9 хувьтай болж сайн өсөлтийг харуулж байна.

## 2.6.1 Үйл ажиллагааны ил тод байдал

### **Байгууллагын ерөнхий мэдээлэл.**

Байгууллагын ерөнхий мэдээлэл буюу эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлээ тавьсан байдал сайн үр дүнтэй байна.

Дүрс 52. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)



Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг цахим хуудсандаа тавьсан байдал 100 хувийн үзүүлэлттэй байгаан нь 2014 оны үр дүнгээс 80 орчим хувиар өссөн үзүүлэлт байна. Цахим хуудсандаа эрхэм зорилгоо байршуулсан байдал 88,9 хувьтай, тэргүүлэх чиглэлээ байршуулсан байдал нь 77,8 хувьтай байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад өссөн үзүүлэлтийг илэрхийлж байна.


### **Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл.**

Байгууллагын олон нийттэй харилцах мэдээллүүд цахим хуудсанд байршсан байдлын авч үзвэл, байгууллагын утас, факс, хаяг, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээлэл 100 хувь мэдээлэгджээ.

Харин иргэдийн үйлчилгээ авахтай холбоотой бүрдүүлэх материалын жагсаалт, олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр, иргэдийн хүлээж авч уулзах цагийн хувиар маш бага хувьтай нийтлэгдсэн бол цахим хуудаснаас шууд холбогдох байдал, шуудангийн хаяг зэрэг мэдээлэл аль ч байгууллагын хувьд нийтэд мэдээлэгдээгүй байна.



Дүрс 53. Парламентын харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)



2014 оны судалгааны үр дүнтэй байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээллээ тавих байдлыг нь харьцуулж харвал, үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт 44,4 хувиас 22,2 хувь буурсан, бусад үзүүлэлтийн хувьд ямар нэгэн байдлаар өссөн үзүүлэлтийг харуулж байна.

**Хүний нөөцийн ил тод байдал.**


Байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлтүүдийг хүний нөөцийн мэдээлэл байгаа эсэх, тус мэдээллийн эх сурвалж байгаа эсэх, цаг хугацааны хувьд тохирсон байдал зэрэг шалгуураар дараах хүснэгтэнд харууллаа.

Дүрс 54. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)



Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ 24,4 хувьтай байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 12 хувиар өссөн үзүүлэлт байна. Мэдээллийн эх сурвалж тодорхой байдал өмнөх жилийн судалгааны үр дүнгээс ахицтай байгаа ч бусад 2 үзүүлэлтийн хувьд 1-2 функтаар буурсан байдалтай байна.

Дүрс 55. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)




Албан хаагчийн ёс зүйн дүрэм байгууллагуудын цахим хуудсанд 88,9 хувьтай, сул орон тооны зар 55,6 хувьтай, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам 11,1 хувьтай байгаан нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад бүхий л үзүүлэлтийн хувьд өссөн байна.

Ялангуяа сул орон тооны зар 2014 оны судалгаагаар 9,5 хувьтай байснаа 55,6 хувь болж 50 орчим хувиар эрс нэмэгджээ.

### 2.6.2 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсөв, санхүүгийн ил тод байдалд үндэслэсэн үзүүлэлтүүдийг доорх үр дүнгүүдээр илэрхийлж байна.

Дүрс 65. Парламентын харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Парламентийн байгууллагуудын төсөв санхүүгийн талаарх мэдээллээ нийтэлж байгаа байдал 20,8 хувьтай, тус мэдээллүүдийнхээ эх сурвалжийг тодорхой нийтлэх байдал 11,1 хувьтай, цаг хугацааны тохиромжтой үед нь оруулж буй байдал 12,3 хувьтай байна. 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад төсөв санхүүгийн холбогдолтой мэдээллийнхээ эх сурвалжийг оруулах байдал 0 байсан бол 11,1 болж өссөн нь бусад үзүүлэлттэй харьцуулахад эрс өсөлтийг харуулж байна.


Төсөв санхүүгийн мэдээллээ бусдаас илүү мэдээллэж байгаа топ байгууллагуудыг жагсааж, дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 25. Төсөв, санхүүгийн ил тод байдал ТОП 4 (хувь)

Нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодор-хой эсэх		Цагхугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Санхүүгийн зохицуулах хороо		19.4		13		12.3		44.7
Хүний эрхийн үндэсний комисс		19.4		13		8.2		40.6
Төрийн албаны зөвлөл		19.4		7.8		12.3		39.5
Нийт дундаж		4.3		4.04		11.7		46.9

Дээрх байгууллагуудаас “Сонгуулийн ерөнхий хороо” 62,3 хувийн үзүүлэлттэй төсөв, санхүүгийн мэдээллээ “ил тод”-оор мэдээллэдэг гэсэн ангилалд байгаа бол, АТГ, СЗХ, ҮСХ зэрэг байгууллагууд “зарим талаар ил тод” гэсэн ангилалд орохоор үнэлэгджээ.

Зураг 12. УАГ-ын төсөв, санхүүгийн ил тод байдал




Ундэсний аудитын газар нь төрийн гол байгууллагуудын санхүүгийн аудитын тайланг татаж болохоор тавьсан ба өөрсдийн зарим тайланг мөн байршуулжээ.

Ерөнхийдөө парламентын харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдал 44,1 хувьтай байгаа нь 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулахд 15 орчим хувиар сайжирсан үзүүлэлтийг харуулж байна.

### 2.6.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээг дор харууллаа.

Дүрс 56. ХАА-ны ил тод байдал (хувь)




Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээ 36,9 хувьтай байгаа нь “бүрэн хаалттай” гэсэн ангилалд орохуйц үзүүлэлт юм. Гэвч 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулан үзвэл 19,4 хувиас 17,5 хувиар өсөлттэй байгааг илтгэх үзүүлэлт болж байна.

ХАА-ны талаар мэдээлэл байгаа эсэх 16,2 хувьтай, тус мэдээллийн эх сурвалж байгаа эсэх 10,2 хувьтай, цаг хугацааны хувьд тохиромжтой байдал 10,5 хувьтай байгаа нь бүхий л үзүүлэлтээр өмнөх жилийн үнэлгээнээс өсөлттэй үр дүнтэй байна. Ялангуяа мэдээллийн эх сурвалжийг байршуулах байдал нэлээд их хувиар өссөн байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлын үзүүлэлтүүдийг 2 оноор харьцуулан дараах дүрсээр харуулж байна.

Дүрс 57. Парламентын харьяа байгууллагуудын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)



Худалдан авсан бараа үйлчилгээний тайлан, тендерийн урилга, ХАА-нд хийсэн аудит болон бусад хяналт, шалгалтын үр дүнгүүд 2014 судалгаатай харьцуулагдаж болох бөгөөд бүгд 20-30 хувиар өссөн, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл хэвэндээ байгааг харж болохоор байна.

Харин энэ жилээс шинээр үнэлэгдэж буй шалгууруудын хувьд, 5-саяас дээш мөнгөн гүйлгээний баримт, тендерт оролцохыг хүсэгчдийн шалгуур үзүүлэлт зэрэг нь бусад үзүүлэлттэй харьцуулахад өндөр хувьтай дүгнэгдсэн бол үлдсэн 3-н шалгуурын хувьд 11,1 хувьтай байгаа нь төдийлөн сайн биш үзүүлэлт юм

## ХАВСРАЛТ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Төрийн байгууллын “ил тод” болон “нээлттэй байдал” гэдэг нь ялгаатай ойлголтууд бөгөөд уг мониторинг эхний ойлголтод суурилна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа. Хөгжлийн Байгууллагын тодорхойлсноор ил тод байдал бол сайн засаглалын тулгын гурван чулуу болох *хариуцан тайлагнах байдал* (accountability); ил *тод байдал* (transparency). *Нээлттэй байдал* (openness)-ын нэг бүрэлдэхүүн хэсэг юм (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази. Номхон Далайн Эдийн засаг Нийгмийн Комисс ил тод байдлыг сайн засаглалыг илэрхийлэх найман шинж байдлын нэг гэж үзээд энэ нь нээлттэй байдал гэх ойлголтоос тусдаа болохыг тэмдэглэжээ. Мөн бидний судалгаандаа гол мөрдлөг болгон ашиглаж буй 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” нь нээлттэй байдлыг гэхээс илүүтэй ил тод байдлыг онцлон авч үзсэн байна. Тиймээс эдгээрээс үндэслэн мониторинг нь “ил тод” байдлыг онцлон шинжилсэн.

**Ил тод байдал:** “Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь найдвартай. холбогдолтой. цаг үеэс хоцролгүй олон нийтэд хүрч байгааг хэлнэ” (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн комисс “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр. үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй. хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ (UNESCAP, 2011).

**Цахим үйлчилгээ:** Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлдэг үндсэн үйлчилгээг цахим хуудсаар дамжуулан үзүүлэх

**Цахим оролцоо:** Төрийн байгууллагын үйл ажиллагаа болон гаргаж буй хууль. тогтоол.

**Төрийн байгууллагын цахим хуудас:** Төрийн байгууллагаас өөрсдийн шийдвэр. үйл ажиллагаа. бүтээгдэхүүн болон иргэдэд шаардлагатай. хуулиар хориогүй бусад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх. төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэхэд зориулсан вэб технологид суурилсан мэдээллийн систем

**Байгууллагын бүтэц. зохион байгуулалт:** Тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулахад баримтлах хууль. эрхзүйн актаар баталгаажуулсан албан ёсны бүтэц. зохион байгуулалт

**Байгууллагын үйл ажиллагаа:** Тухайн байгууллагын өдөр тутмын болон иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагаа

**Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:** Төрийн байгууллагын албан хаагчийн ажлын зар болон сонгож авах шалгуур үзүүлэлт. түүнтэй холбоотой баримт бичгийг иргэд олж авах боломжоор хангасан байдал

**Төсөв. санхүүгийн ил тод байдал:** УИХ-аас батлан тухайн төрийн байгууллагад зарцуулах эрх олгосон төсөв. түүний зарцуулалт. төсвийн төсөл. мөн эдгээр баримт бичигт хийгдсэн аудит болон бусад хяналтын тайланг иргэдэд ойлгомжтой байдлаар түгээх. түүнийг ашиглах боломж олгосон байдал

**Худалдан авах ажиллагааны ил тод байдал:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа. ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдэж буй бүхий л

худалдан авалтын урилга болон холбогдох баримт бичгүүдийг ашиглахад хялбар байдлаар иргэдэд түгээх. түүнийг ашиглах боломж олгосон байдаг.

## ХАВСРАЛТ 2. АРГА ЗҮЙН ТАЙЛБАР

Хүснэгт 26. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт	Хэмжүүр	Хүрээ
<b>Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance)</b>	Тухайн цахим хуудас нь МИТББМАЭТХ болон ШДТХ-д заасан мэдээллүүдийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэх	Мэдээлэл цогц бүрэн байгаа эсэх	Үйл ажиллагаа
			Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
<b>Мэдээллийн найдвартай байдал (Reliability)</b>	Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэх	Мэдээллийн эх сурвалж тодорхой байгаа эсэх	Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
<b>Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness)</b>	Цахим хуудас цаг үеийн. ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэх	Тухайн мэдээллийг оруулсан хугацаа тодорхой эсэх	Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
		Тухайн мэдээлэл хэрэглэгчдэд зориулж боломжит хугацаанд нийтлэгдэж байгаа эсэх	Худалдан авах ажиллагаа
			Хүний нөөц
		Тухайн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг эсэх	Хүний нөөц
			Төсөв. санхүү байдал
<b>Цахим хуудасны хүртээмжтэй байдал (Accessibility)</b>	Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагаас шууд хандан мэдээлэл авах боломж олгосон. мөн хоёр талын оролцоог хангасан эсэх	Асуулт хариултын булан байгаа эсэх	
		Хэлэлцүүлгийн булан байгаа эсэх	
		Холбоотой байгууллагын холбоос линк байгаа эсэх	
		Тогтмол асуудаг асуултуудын хариулт байгаа эсэх (FAQ)	
		Хэлний сонголт байгаа эсэх	
<b>Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (Usability)</b>	Хэрэглэгчдэд тухайн цахим хуудсын бүтэц. дизайн. үзэмж зэрэг нь ашиглахад хялбар байгаа эсэх	Цахим хуудасны үсгийн хэмжээ тохиромжтой. харагдахуйц байгаа эсэх	
		Цахим хуудасны цэс ойлгомжтой эсэх	
		Цахим хуудас өнгөний зохицолтой эсэх	
		Цахим хуудасны бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байгаа эсэх	
		Цахим хуудасны мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байгаа эсэх	
		Дурын браузерээс тухайн цахим хуудас руу орох боломж байгаа эсэх	
		Цахим хуудаст алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байгаа эсэх	
		Цахим хуудаст хайлтын цэс байгаа эсэх	
		Цахим хуудаст цахим шуудангийн хаяг байгаа эсэх	
		Цахим хуудаснаас хэвлэх боломж байгаа эсэх	
Цахим хуудаст файлыг хадгалах боломж байгаа эсэх			



## Цахим хуудаснаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх

Хүснэгт 27. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ

Хувь	Холбогдолтой байдал	Найдвартай байдал	Цаг үеийн байдал	Хүртээмжтэй байдал	Хэргэлэхэд хялбар байдал	Ил тод байдал
81-100	Бүрэн холбогдолтой	Мэдээлэл бүрэн найдвартай	Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг	Бүрэн хүртээмжтэй	Хэргэлэхэд маш хялбар	Бүрэн ил тод
61-80	Холбогдолтой	Найдвартай	Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг	Хүртээмжтэй	Хэргэлэхэд боломжтой	Ил тод
41-60	Зарим талаар холбогдолтой	Зарим талаар найдвартай	Зарим мэдээлэл шинэчлэгддэг	Зарим талаар хүртээмжтэй	Хэргэлэхэд төвөгтэй	Зарим талаар ил тод
0-40	Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй	Найдваргүй	Хоцрогдсон мэдээлэл	Хүртээмжгүй	Хэргэлэхэд маш төвөгтэй	Хаалттай

Хүснэгт 28. 2015 оны мониторингийн аргазүйд нэмж оруулсан шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтийн хүрээ	Нэмсэн үзүүлэлт	Эх сурвалж
<b>Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал</b>	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт	МИТББМАЭТХ-ийн 7.1.3-р зүйл
	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар	МИТББМАЭТХ-ийн 7.1.4-р зүйл
<b>Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</b>	Албан хаагчийн ёс зүйн дүрэм	МИТББМАЭТХ-ийн 8.1.3-р зүйл
	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	МИТББМАЭТХ-ийн 8.1.4-р зүйл
	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа	МИТББМАЭТХ-ийн 8.1.5-р зүйл
<b>Төсөв, санхүүгийн ил тод байдал</b>	Шилэн дансны тусгай цэс байгаа эсэх	ШДТХ-ийн 5.1.1-р зүйл
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	ШДТХ-ийн 6.1.1-р зүйл
	Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл	ШДТХ-ийн 6.1.5-р зүйл
	Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар	ШДТХ-ийн 6.1.5-р зүйл
<b>Худалдан авах ажиллагааны ил тод байдал</b>	Тендерийн баримт бичиг	ШДТХ-ийн 6.4.3-р зүйл
	Тендер шалгаруулалт явуулах журам	ШДТХ-ийн 6.4.3-р зүйл
	Тендер оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт	ШДТХ-ийн 6.4.3-р зүйл
	Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга	ШДТХ-ийн 6.4.5-р зүйл
	Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр/бонд, зээл, өрийн бичиг гэх мэт/	ШДТХ-ийн 6.4.8-р зүйл

## ХАВСРАЛТ 3. СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ЦАХИМ ХУУДСУУД

### Монгол Улсын яам

1.	Байгаль орчин аялал жуулчлалын яам	<a href="http://www.mne.mn/">http://www.mne.mn/</a>
2.	Монгол улсын гадаад харилцааны яам	<a href="http://www.mfa.gov.mn/">http://www.mfa.gov.mn/</a>
3.	Сангийн Яам	<a href="http://mof.gov.mn">mof.gov.mn</a>
4.	Хууль зүй, дотоод хэргийн яам	<a href="http://www.mjia.gov.mn/">http://www.mjia.gov.mn/</a>
5.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	<a href="http://www.khun.gov.mn/">http://www.khun.gov.mn/</a>
6.	Барилга, хот байгуулалтын яам	<a href="http://www.mcup.gov.mn/">http://www.mcup.gov.mn/</a>
7.	Монгол улсын батлан хамгаалах яам	<a href="http://www.mod.gov.mn/">http://www.mod.gov.mn/</a>
8.	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам	<a href="http://www.meds.gov.mn/">http://www.meds.gov.mn/</a>
9.	Зам, тээвэр хөгжлийн яам	<a href="http://mrted.gov.mn/">http://mrted.gov.mn/</a>
10.	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн яам Веб сайт	<a href="http://mofa.gov.mn/new/">http://mofa.gov.mn/new/</a>
11.	Эрчим хүчний яам	<a href="http://energy.gov.mn/">http://energy.gov.mn/</a>
12.	Эрүүл мэндийн яам	<a href="http://www.mohs.mn/">http://www.mohs.mn/</a>
13.	Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яам	<a href="http://www.mm.gov.mn/">http://www.mm.gov.mn/</a>

### 2.1 Хэрэгжүүлэгч агентлаг

1.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	<a href="http://e-tender.mn/">http://e-tender.mn/</a>
2.	Биений тамир, спортын газар	<a href="http://www.ipom.gov.mn/">http://www.ipom.gov.mn/</a>
3.	Цаг уур, орчны шинжилгээний газар	<a href="http://namem.gov.mn/">http://namem.gov.mn/</a>
4.	Гаалийн ерөнхий газар	<a href="http://www.customs.gov.mn/">http://www.customs.gov.mn/</a>
5.	татварын ерөнхий газар	<a href="http://www.mta.mn/">http://www.mta.mn/</a>
6.	улсын бүртгэл оюуны өмчийн газар	<a href="http://burtgel.gov.mn/">http://burtgel.gov.mn/</a>
7.	Архивын ерөнхий газар	<a href="http://archives.gov.mn/">http://archives.gov.mn/</a>
8.	шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	<a href="http://cd.gov.mn/mn/">http://cd.gov.mn/mn/</a>
9.	гадаад иргэн харьяатын газар	<a href="http://immigration.gov.mn/new/">http://immigration.gov.mn/new/</a>
10.	Соёл урлагийн газар	<a href="http://takhar.gov.mn/">http://takhar.gov.mn/</a>
11.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	<a href="http://www.gazar.gov.mn/">http://www.gazar.gov.mn/</a>
12.	Иргэний нисэхийн ерөнхий газар	<a href="http://www.mcaa.gov.mn/?page_id=6478">http://www.mcaa.gov.mn/?page_id=6478</a>
13.	Ашигт малтмал газрын тосны газар	<a href="http://mram.gov.mn/">http://mram.gov.mn/</a>
14.	Мал эмнэлэг, үржлийн газар	<a href="http://dvab.gov.mn/">http://dvab.gov.mn/</a>
15.	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	<a href="http://www.ndaatgal.mn/">http://www.ndaatgal.mn/</a>
16.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	<a href="http://zasag.mn/m/social-welfare-service/policy">http://zasag.mn/m/social-welfare-service/policy</a>
17.	Хүүхэд залуучуудын хөгжлийн газар	<a href="http://zasag.mn/m/nac">http://zasag.mn/m/nac</a>

### 2.2 Тохируулагч агентлаг

1.	Тагнуулын ерөнхий газар	<a href="http://www.gia.gov.mn/">http://www.gia.gov.mn/</a>
2.	Төрийн өмчийн хороо	<a href="http://www.spc.gov.mn/">http://www.spc.gov.mn/</a>
3.	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	<a href="http://cita.gov.mn/?page_id=25">http://cita.gov.mn/?page_id=25</a>
4.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	<a href="http://inspection.gov.mn/index.php/en/">http://inspection.gov.mn/index.php/en/</a>
5.	Онцгой байдлын ерөнхий газар	<a href="http://nema.gov.mn/">http://nema.gov.mn/</a>
6.	Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	<a href="http://www.afccp.gov.mn/mn">http://www.afccp.gov.mn/mn</a>
7.	Стандарчлал, хэмжил зүйн газар	<a href="http://www.masm.gov.mn/mn/">http://www.masm.gov.mn/mn/</a>
8.	Цагдаагийн ерөнхий газар	<a href="https://www.police.gov.mn/">https://www.police.gov.mn/</a>
9.	Хил хамгаалах ерөнхий газар	<a href="http://bpo.gov.mn/">http://bpo.gov.mn/</a>
10.	Зэвсэгт хүчний жанжин штаб	<a href="http://gsmaf.gov.mn/">http://gsmaf.gov.mn/</a>

**Орон нутгийн ЗДТГ**

1.	Архангай	<a href="http://www.arkhangai.gov.mn">http://www.arkhangai.gov.mn</a>
2.	Баян-Өлгий	<a href="http://www.bayanulgii.gov.mn">http://www.bayanulgii.gov.mn</a>
3.	Баянхонгор	<a href="http://www.bayankhongor.mn">http://www.bayankhongor.mn</a>
4.	Булган	<a href="http://www.bulgan.gov.mn">http://www.bulgan.gov.mn</a>
5.	Говь-Алтай	<a href="http://www.govi-altai.gov.mn">http://www.govi-altai.gov.mn</a>
6.	Говьсүмбэр	<a href="http://www.govisumber.gov.mn">http://www.govisumber.gov.mn</a>
7.	Дархан-Уул	<a href="http://www.e-darkhan.com">http://www.e-darkhan.com</a>
8.	Дорноговь	<a href="http://www.dornogobi.gov.mn">http://www.dornogobi.gov.mn</a>
9.	Дорнод	<a href="http://www.dornod.gov.mn">http://www.dornod.gov.mn</a>
10.	Дундговь	<a href="http://www.dundgovi.gov.mn">http://www.dundgovi.gov.mn</a>
11.	Завхан	<a href="http://www.zavkhan.mn">http://www.zavkhan.mn</a>
12.	Орхон	<a href="http://www.erdenet.mn">http://www.erdenet.mn</a>
13.	Өвөрхангай	<a href="http://www.uvurkhangai.gov.mn">http://www.uvurkhangai.gov.mn</a>
14.	Өмнөговь	<a href="http://www.umnugovi.gov.mn">http://www.umnugovi.gov.mn</a>
15.	Сүхбаатар	<a href="http://www.sukhbaatar.mn">http://www.sukhbaatar.mn</a>
16.	Сэлэнгэ	<a href="http://www.selenge.mn">http://www.selenge.mn</a>
17.	Төв	<a href="http://www.tuv.mn">http://www.tuv.mn</a>
18.	Увс	<a href="http://www.uvsmongolia.mn">http://www.uvsmongolia.mn</a>
19.	Хөвсгөл	<a href="http://www.huvsgul.mn">http://www.huvsgul.mn</a>
20.	Хэнтий	<a href="http://khentii.mn/">http://khentii.mn/</a>
21.	Ховд	<a href="http://www.khovd.gov.mn/">http://www.khovd.gov.mn/</a>

**Парламентийн харъяа байгууллагууд**

1.	Төрийн Албаны Зөвлөл	<a href="http://csc.gov.mn">http://csc.gov.mn</a>
2.	Авлигатай Тэмцэх Газар	<a href="http://www.iaac.mn/">http://www.iaac.mn/</a>
3.	Санхүүгийн Зохицуулах Хороо	<a href="http://www.frc.mn/">http://www.frc.mn/</a>
4.	Сонгуулийн Ерөнхий Хороо	<a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a>
5.	Хүний Эрхийн Үндэсний Комисс	<a href="http://www.mn-nhrc.org">www.mn-nhrc.org</a>
6.	Үндэсний Аудитын Газар	<a href="http://www.mnao.mn">www.mnao.mn</a>
7.	Үндэсний Статистикийн Хороо	<a href="http://www.nso.mn/">www.nso.mn/</a>
8.	Монгол Банк	<a href="http://www.mongolbank.mn">www.mongolbank.mn</a>
9.	Монгол Улсын Их Хурал	<a href="http://www.parliament.mn">www.parliament.mn</a>

**Улаанбаатарын дүүргүүдийн ЗДТГ**

1.	Нийслэл Улаанбаатар хот	<a href="http://www.ulaanbaatar.mn">http://www.ulaanbaatar.mn</a>
2.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	<a href="http://ubservice.ub.gov.mn/">http://ubservice.ub.gov.mn/</a>
3.	Баянгол дүүрэг	<a href="http://www.bgd.mn">http://www.bgd.mn</a>
4.	Багахангай дүүрэг	<a href="http://www.bagakhangai.ub.gov.mn">http://www.bagakhangai.ub.gov.mn</a>
5.	Баянзүрх дүүрэг	<a href="http://www.bzd.ub.gov.mn/">http://www.bzd.ub.gov.mn/</a>
6.	Багануур дүүрэг	<a href="http://bnd.ub.gov.mn/">http://bnd.ub.gov.mn/</a>
7.	Чингэлтэй дүүрэг	<a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a>
8.	Сүхбаатар дүүрэг	<a href="http://www.sbd.ub.gov.mn">www.sbd.ub.gov.mn</a>
9.	Сонгинохайрхан дүүрэг	<a href="http://www.shd.mn/">www.shd.mn/</a>
10.	Хан-Уул дүүрэг	<a href="http://www.khanuul.mn">www.khanuul.mn</a>
11.	Налайх дүүрэг	<a href="http://www.nad.ub.gov.mn">www.nad.ub.gov.mn</a>

## ХАВСРАЛТ 4. ЦАХИМ ХУУДСУУДЫН ЭРЭМБЭЛЭЛТ

Байр	Төрийн байгууллагууд	Мэдээллийн хамааралтай байдал	Мэдээллийн найдвартай байдал	Мэдээллийн цаг үеийн байдал	Мэдээллийн хүртээмжтэй байдал	Цахим хуудас хэрэглэхэд хялбар байдал	Нийлбэр хувь
1	Баянхонгор аймаг	27.8	19.1	15.0	6	12.3	80.1
2	Орхон аймаг	21.0	15.5	15.4	12	10.9	74.7
3	Иргэний нисэхийн ерөнхий газар	26.2	18.1	15.1	3	9.5	71.9
4	Сүхбаатар дүүрэг	22.5	16.4	15.8	9	6.8	70.5
5	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	21.5	17.1	17.1	6	8.2	70.0
6	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	21.5	14.3	12.2	9	12.5	69.6
7	шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	23.1	17.1	15.9	6	6.8	69.0
8	Дорнод аймаг	19.5	15.5	14.6	9	9.5	68.1
9	гадаад иргэн харьяатын газар	22.3	14.3	13.5	9	6.8	65.9
10	Сангийн Яам	18.5	14.3	14.3	6	9.5	62.6
11	эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	17.7	12.4	10.6	9	12.3	62.0
12	татварын ерөнхий газар	18.5	10.5	8.6	12	12.3	61.8
13	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам	20.0	10.5	11.0	12	8.2	61.7
14	Хан-Уул дүүрэг	23.3	13.6	12.7	3	8.2	60.8
15	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	18.5	15.2	15.5	3	8.2	60.4
16	Сүхбаатар аймаг	19.5	16.4	15.8	3	5.5	60.1
17	улсын бүртгэл оюуны өмчийн газар	18.5	12.4	9.0	12	8.2	60.0
18	Зам, тээвэр хөгжлийн яам	19.2	8.6	10.6	9	9.5	57.0
19	Налайх дүүрэг	18.8	13.6	13.1	3	8.2	56.6
20	Говьсүмбэр аймаг	18.0	15.5	10.4	3	9.5	56.4
20	Хэнтий	20.3	14.5	10.4	3	8.2	56.4
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	19.2	11.4	8.6	6	10.9	56.1
22	Эрүүл мэндийн яам	19.2	10.5	10.6	6	9.5	55.9
23	Нийслэл Улаанбаатар хот	21.0	13.6	12.7	3	5.5	55.8
24	Баян-Өлгий аймаг	21.0	3.6	12.3	6	12.3	55.2
24	Багахангай дүүрэг	18.0	13.6	13.1	3	7.5	55.2
25	Байгаль орчин аялал жуулчлалын яам	17.7	12.4	11.8	6	6.8	54.7
26	Чингэлтэй дүүрэг	20.3	13.6	12.3	3	5.5	54.6
27	стандарчлал, хэмжил зүйн газар	16.9	13.3	9.4	6	8.8	54.4
27	Багануур дүүрэг	17.3	13.6	12.3	3	8.2	54.4

28	онцгой байдлын ерөнхий газар	16.2	12.4	9.8	6	9.5	53.9
29	Дархан аймаг	16.5	12.7	11.9	3	9.5	53.7
30	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн яам Веб сайт	18.5	11.4	10.6	6	6.8	53.3
31	цагдаагийн ерөнхий газар	15.4	10.5	8.6	12	6.8	53.3
32	Архивын ерөнхий газар	16.2	10.5	8.2	6	12.3	53.1
33	Соёл урлагийн газар	16.9	16.2	7.3	3	9.5	53.0
34	Монгол улсын батлан хамгаалах яам	13.8	13.3	13.5	3	8.2	51.8
35	Завхан аймаг	16.5	10.9	9.6	3	10.9	50.9
36	Архангай аймаг	15.0	12.7	10.0	6	6.8	50.5
37	Барилга, хот байгуулалтын яам	15.4	10.5	11.4	3	9.5	49.8
38	Баянзүрх дүүрэг	14.3	8.2	8.5	9	9.5	49.4
39	Монгол банк	16.9	7.6	9.8	6	8.2	48.5
40	Монгол улсын гадаад харилцааны яам	11.5	8.6	9.8	9	9.5	48.5
41	Сонгинохайрхан дүүрэг	18.0	10.9	9.6	3	6.8	48.3
42	Төв аймаг	14.3	10.9	8.1	6	8.2	47.4
43	мал эмнэлэг, үржлийн газар	16.2	11.4	8.2	3	8.2	46.9
44	Дундговь аймаг	12.8	9.1	8.1	6	9.5	45.5
45	Сэлэнгэ аймаг	15.8	9.1	9.2	3	8.2	45.3
46	Авлигатай тэмцэх газар	11.5	7.6	7.3	6	12.3	44.8
47	төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	16.2	9.5	5.7	6	6.8	44.2
48	зэвсэгт хүчний жанжин штаб	12.3	10.5	11.4	3	6.8	44.0
49	Увс аймаг	10.5	7.3	4.6	12	9.5	43.9
49	хил хамгаалах ерөнхий газар	12.3	8.6	6.5	9	7.5	43.9
50	Ховд	13.5	8.2	8.8	3	9.5	43.1
51	Гаалийн ерөнхий газар	14.6	4.8	2.0	12	9.5	43.0
52	ашигт малтмал газрын тосны газар	12.3	7.6	7.3	6	8.2	41.5
53	Сонгуулийн ерөнхий хороо	9.2	5.7	4.9	9	12.3	41.1
54	Биеийн тамир, спортын газар	10.0	7.6	6.5	9	6.8	40.0
55	Баянгол дүүрэг	14.3	7.3	8.1	3	6.8	39.4
56	Өвөрхангай аймаг	13.5	8.2	6.5	3	6.8	38.0
57	Хүний эрхийн үндэсний комисс	12.3	6.7	4.1	6	8.2	37.2
58	Санхүүгийн зохицуулах хороо	11.5	4.8	4.9	6	9.5	36.7
59	Өмнөговь аймаг	15.0	7.3	5.4	0	8.2	35.8
60	Эрчим хүчний яам	12.3	4.8	4.1	3	10.9	35.1
61	Монгол улсын Их хурал	9.2	1.9	4.1	9	9.5	33.8
62	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	12.3	2.9	1.6	6	10.9	33.7
63	Төрийн албаны зөвлөл	11.5	3.8	5.3	6	6.8	33.5

64	Говь-Алтай аймаг	10.5	6.4	5.4	3	8.2	33.4
65	Үндэсний статистикийн хороо	9.2	1.9	1.6	9	9.5	31.3
65	Мэдээллийн технологи, шуудан , харилцаа холбооны газар	9.2	4.8	4.5	6	6.8	31.3
66	Хөвсгөл	12.0	10.9	8.1	0	0.0	31.0
67	шудрага өрсөлдөөн , хэрэглэгчийн төлөө газар	9.2	3.8	2.9	6	7.5	29.4
68	Булган аймаг	11.3	1.8	0.4	6	8.2	27.6
69	Тагнуулын ерөнхий газар	6.9	1.9	0.8	6	9.5	25.2
70	Үндэсний аудитын хороо	10.0	2.9	1.6	3	5.5	22.9
71	Дорноговь аймаг	7.5	2.7	1.2	3	8.2	22.6
72	Хууль зүй, дотоод хэргийн яам	6.9	1.9	1.2	3	8.2	21.2
73	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	4.6	1.0	0.0	0	5.5	11.0
74	Хүүхэд залуучуудын хөгжлийн газар	4.6	1.0	0.0	0	5.5	11.0
75	Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яам	0.0	1.0	0.0	0	1.4	2.3
76	Төрийн өмчийн хороо	0.0	1.0	0.0	0	0.0	1.0

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН